



МОНГОЛ ОРНЫ REDD+-ИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ МЭДЭЭЛЛИЙН СИСТЕМ: САНАЛ БОЛГОЖ БАЙГАА БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

1-р бүлэг: Үндсэн тайлан

2018 оны 10 сар

Тайлан боловсруулсан:

Ж. Амармаа*, Д.Аннандэйл**, Ш.Хикс. Д. Энхжаргал (2018) Монгол орны REDD+-ийн Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем: Санал болгож байгаа бүтэц зохион байгуулалт, гүйцэтгэх үүрэг, хариуцлага. 2018 оны 10 сар

Тайланг ашиглах зөвшөөрөл

Уг тайлангийн эх сурвалжийг дурдсан тохиолдолд урьдчилж бичгээр зөвшөөрөл авахгүйгээр сургалтын болон бусад арилжааны бус зориулалтаар олшруулан хэвлэж болно.

Энэхүү тайланд зөвхөн зохиогчдын үзэл санаа тусгагдсан бөгөөд энэ нь Монгол орны UN-REDD Хөтөлбөр болон хамтран ажилладаг байгууллагуудын байр суурийг илэрхийлээгүй болно.

Талархал

Уг баримт бичгийг боловсруулахад үнэтэй санал, зөвлөгөө өгсөн СНСЗ болон СНСМС-ийг боловсруулах техникийн ажлын хэсгийн гишүүд, Монгол орны UN-REDD хөтөлбөрийн баг болон техник, арга зүйн туслалцаа үзүүлсэн UN-REDD хөтөлбөрийн бүсийн болон олон улсын зөвлөхүүд, НҮБ-ын Байгаль орчин, дэлхийн байгаль хамгаалал, хяналтын төв (UNEP-WCMC)-д талархал илэрхийлье.

Холбоо барих

Энэхүү тайлан болон бусад холбогдох үйл ажиллагааны талаар нэмэлт мэдээлэл авах бол БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Оюунсанаатай oyunsanaa@mne.gov.mn хаягаар холбоо барина уу.

* Үндэсний зөвлөх

** Олон улсын зөвлөх

† НҮБ-ын Байгаль орчны ажиглалт, хяналтын төв (UNEP-WCMC)

Агуулга

Товчилсон үгс	4
1. Танилцуулга	5
1.1 Монгол оронд REDD+ ийг хэрэгжүүлэх нь.....	5
1.2 СНСЗ ба СНСМС-тэй холбоотой тавигдах шаардлагууд	6
1.3. Тайлангийн бүтэц	7
2. Монгол орны онцлогт тохирсон Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем байгуулах нь	8
3. Монгол орны СНСМС-ийн загварын бүрэлдэхүүн хэсгүүд	12
3.1 СНСМС-ийн зорилго.....	12
3.2 Мэдээллийн хэрэгцээ ба бүтцийг тодорхойлох	14
3.3 СНСМС-ийн институцийн зохион байгуулалт	20
3.4 СНСМС-ийг байгуулах арга барил	24
4. СНСМС-ийг ажиллуулахтай холбоотой хэрэгцээ шаардлага	30
4.1 Бодлого болон институцийн зохион байгуулалттай холбоотой шаардлага	30
4.2 Хүний нөөцийн хэрэгцээ	31
4.3 Техникийн тусгай мэргэжилтэн, технологи тоног төхөөрөмжтэй холбоотой хэрэгцээ шаардлага	33
5. Зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх алхмууд	34

Товчилсон үгс

ГЗБГЗЗГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
УАӨТХН	Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэх нэгж
ТБХ	Талуудын бага хурал
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
УАӨГХАГ	Уур амьсгалын өөрчлөлт, гадаад хамтын ажиллагааны газар
ОБЗГ	Ойн бодлого, зохицуулалтын газар
БОМТ	Байгаль орчны мэдээллийн төв
ОСХТ	Ойн судалгаа, хөгжлийн төв
ОСТ/ОЯХХСТ	Ойн суурь түвшин / Ойгоос ялгарах хүлэмжийн хийн суурь түвшин
ОН	Ойн нөхөрлөл
УАНС	Уур амьсгалын ногоон сан
МБОИЗ	Монголын байгаль орчны иргэний зөвлөл
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ХҮ	Хяналт, үнэлгээ
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ТББ	Төрийн бус байгууллага
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
БАХ	Бодлого, арга хэмжээ
БХЖ	Бодлого, хууль, журам
REDD+	Ойн хомсдол доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад Байгаль хамгаалал, ойн тогтвортой менежмент, ойн нүүрстөрөгчийн шингээлтийг нэмэгдүүлэхийн ач холбогдол
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилтууд
СНСМС	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем
(SOI)	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудын хэрэгжилтийн тайлан
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
СНСЗ-	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчим болон Сөрөг нөлөөллөөс сэргийлэх
СНСМС-ийн	мэдээллийн системийг боловсруулах техникийн ажлын хэсэг
ТАХ	
UNEP-WCMC	НҮБ-ын БОХ –Дэлхийн хүрээлэн буй орчны хяналтын төв
НҮБ-ын	НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц
УАӨСК	
UN-REDD	Хөгжиж буй орнуудын ойн хомсдол, доройтлоос үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн НҮБ-ын хамтарсан санаачилга

1. Танилцуулга

Энэхүү тайланд Монгол Улсад анх удаа байгуулахаар зорьж байгаа REDD+-ийн Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем (CHCMS)-ийг боловсруулах загварын бүрэлдэхүүн хэсгүүд болон ашиглаж болох хувилбаруудыг танилцуулав. Энэхүү загварын бүрэлдэхүүн хэсгүүдийг холбогдох оролцогч талуудтай зөвшилцөж, шаардлагатай баримт материалыг судалсны үндсэн дээр боловсрууллаа.

1.1 Монгол оронд REDD+ ийг хэрэгжүүлэх нь

Монгол Улс нь 2015 оноос UN-REDD хөтөлбөрт хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь REDD+ Үндэсний хөтөлбөрийг боловсруулж, НҮБ-ын суурь Конвенцийн Варшавын гэрээний хүрээнд тавигддаг шаардлагуудыг хангахад нь Монгол улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх явдал юм.

2013 онд баталсан REDD+-ийн Варшавын гэрээнд гишүүн улсууд нь дараах 4-н арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой гэсэн шаардлага тавьсан байдаг. Үүнд:

1. Үндэсний стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөөтэй болох
2. Үндэсний хэмжээнд ойгоос ялгарах хүлэмжийн хийн суурь түвшин/ойн суурь түвшинг тодорхойлох, хэрэв боломжтой бол орон нутгийн түвшинд ялгарах хүлэмжийн хийн суурь түвшин буюу ойн суурь түвшинг тогтоосон байх
3. Хяналт тавих, тайлан боловсруулахад зориулсан зохистой, ил тод үндэсний ойн мониторингийн систем бий болгох
4. Үр дүнд суурилсан урамшуулал авахаас өмнө сөрөг нөлөөллөөс сэргийлэх 7 зарчмыг хэрхэн тусгаж хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл цуглуулах, CHC3-уудын хэрэгжилтийн талаарх тайланг гаргахад туслах үүрэгтэй мэдээллийн систем байгуулах зэрэг болно.

Монгол Улс REDD+-д бэлтгэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн бөгөөд үүнд ойн хомсдол, доройтлын хүчин зүйлсийг судлах, Үндэсний REDD+ хөтөлбөрийг боловсруулах, ойн суурь түвшнийг (ОСТ) тогтоосон тайлан илгээх, үндэсний ойн мониторингийн системийг (YOMC) боловсруулах, CHC3-уудыг үндэсний нөхцөлд хэрэгжүүлэх хүрээг тогтоож CHCMS-ийн¹ үндэс суурийг тавих зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тус улс нь Үндэсний REDD+ хөтөлбөрөө боловсруулж байгаа бөгөөд энэ нь үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх REDD+-ийн бодлого, арга хэмжээнүүд (БАХ)²

¹ Монгол Улсад хэрэгжүүлэх CHC3-уудтай холбоотой ажлын талаар нэмэлт мэдээллийг доорх холбоосоор орж авна уу <http://www.unredd.net/announcements-and-news/2592-safeguards-country-resource-hub.html>.

² REDD+-ийн үйл ажиллагаануудыг “бодлого, арга хэмжээ” гэж нэрлэнэ.

болон Варшавын гэрээнд заасан бусад асуудлын талаарх мэдээллийг багтаасан байх юм.

1.2 СНСЗ ба СНСМС-тэй холбоотой тавигдах шаардлагууд

НҮБУАӨСК-ийн хүрээнд баталсан Канкуны гэрээнд (Талуудын бага хурлын шийдвэр 1/СР. 16) гишүүн орнууд REDD+-д бэлтгэх болон цаашид хэрэгжих үйл ажиллагаанаас үүдэж болох сөрөг нөлөөллийг бууруулах, үр ашгийг дээшлүүлэхийг эрмэлзэх үүднээс Канкуны 7 зарчмыг (Хавсралт 1-с харах) бодлого, хууль журамдаа тусгаж, хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн уриалсан байна.

НҮБУАӨСК-ийн Талуудын бага хурлаар REDD+-ийн СНСЗ-уудтай холбоотой дараах шаардлагуудыг дэвшүүлж, гишүүн орнууд санал нэгтэй баталсан байна. Үүнд:

1. REDD+-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа тухайн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр ба төрлөөс үл хамааран сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг дэмжиж хэрэгжүүлэх³,
2. Канкуны зарчмуудыг бодлого, хууль, журамдаа хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаар тайлан мэдээлэл гаргах тусгай мэдээллийн систем бий болгох (тухайлбал: “Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем” –СНСМС)⁴,
3. REDD+-ийг хэрэгжүүлэх явцад сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаар нэгдсэн тайлан (Sol) өгч байх гэжээ⁵.

Иймд СНСМС-ийг боловсруулах нь НҮБУАӨСК-ийн REDD+ хөтөлбөрийн хүрээнд тавьж байгаа гол шаардлага мөн бөгөөд үүнийг байгуулснаар тухайн улс үр дүнд суурилсан урамшуулал авах нэг нөхцөл болно. НҮБУАӨСК-ийн зүгээс боловсруулсан СНСМС-ийн талаарх удирдамжийг 2011 онд Дурбанд зохион байгуулсан хурлын шийдвэрээр баталсан байна. (Шигтгээ 1.)

³ НҮБУАӨСК-ийн Шийдвэр 1/СР.16, 69 хэсэг,

⁴ НҮБУАӨСК-ийн Шийдвэр 1/СР.16, 71(d) хэсэг, Шийдвэр 9/СР.19, 3 хэсэг

⁵ НҮБУАӨСК-ийн Шийдвэр 12/СР.17, 3 хэсэг, Шийдвэр 9/СР.19, 4 хэсэг

Шигтгээ 1: REDD+ Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийн талаар НҮБ-ын УАӨСК-ийн зүгээс гаргасан удирдамж

НҮБ-ын УАӨСК-ийн Талуудын 17-р бага хурлын шийдвэр 12-т заасны дагуу ‘...сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа ... талаарх мэдээллийг боловсруулах системийг бий болгохдоо тухайн улсын нөхцөл байдал, холбогдох чадавх, үндэсний нэгдмэл байдал, хууль тогтоомж, олон улсын холбогдох гэрээ хэлэлцээрийг харгалзан, хүйсийн тэгш байдлын асуудлыг авч үзэх шаардлагатай бөгөөд үүнд:

- а) Холбогдох удирдамжид [REDD+-тэй холбоотой бодлого, эерэг үр дүнгийн урамшууллын талаарх бодлого]...нийцсэн байна;
- б) Бүх шатны оролцогч талуудад хүртээмжтэй байхуйц ил тод, жигд мэдээллээр хангаж, мэдээлэл нь тогтмол шинэчлэгддэг байна;
- в) Ил тод бөгөөд тодорхой хугацааны дараа дахин сайжруулж болохуйц уян хатан байна;
- г) Сөрөг нөлөөллөөс сэргийлэх бүх зарчмыг бодлого хууль журамд ... хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл өгөх;
- д) Тухайн улс өөрөө санаачлан гардаж хэрэгжүүлнэ;
- е) Одоогийн байгаа системүүдэд аль болох суурилсан байна’ гэжээ.

Эх сурвалж: НҮБ-ын УАӨСК-ийн Талуудын бага хурлын Шийдвэр 12/СР.17, хэсэг 2

1.3. Тайлангийн бүтэц

Энэхүү тайлан 2 бүлгээс бүрдэнэ. Эхний бүлэг 4 хэсэгтэй бөгөөд СНСМС-ийн боловсруулахад авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаанууд, СНСМС-ийн загварын бүрэлдэхүүн хэсгүүд, уг системийг ажиллуулахтай холбоотой шаардлагатай эх үүсвэр, хөрөнгө, талуудаас өгсөн зөвлөмж болон цаашид хэрэгжүүлэх алхмуудын талаар тусгасан болно.

Тайлангийн 2 дугаар бүлэг нь үндсэндээ сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмууд; СНСМС-д шаардлагатай мэдээллийн хэрэгцээ болон шалгуур үзүүлэлт; СНСМС-ийн загварын бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох зөвлөлдөх уулзалт болон хэлэлцүүлгээс гарсан үр дүн зэргийг танилцуулсан хавсралтуудаас бүрдэнэ.

2. Монгол орны онцлогт тохирсон Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем байгуулах нь

REDD+-ийн СНСЗ-уудыг хэрэгжүүлэхдээ тухайн улсын онцлог хэрэгцээ болон нөхцөл байдалд тохируулах ёстой гэж үздэг. СНСЗ-уудыг тухайн улсад хэрэгжүүлэх ажил нь дараах үндсэн 3 хэсгээс бүрдсэн байна⁶.

1. СНСЗ-тай холбоотой, тухайн улсад хэрэгжиж байгаа бодлого, хууль журмууд (БХЖ)
2. Холбогдох хууль журмуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой институцийн чиг үүрэг, журам, чадавх
3. REDD+-ийн СНСЗ-уудыг хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаарх мэдээллийг боловсруулах сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн систем (СНСМС) зэрэг болно.


Монгол Улсад REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг боловсруулах, мөн СНСМС-ийг бий болгох ажлыг тодорхой үе, шаттайгаар гүйцэтгэж ирсэн. Эдгээрийг боловсруулахдаа одоогийн байгаа хууль, журам, институц болон мэдээллийн системд аль болох түшиглэхийг эрмэлзэж байгаа бөгөөд ингэснээр Монгол Улс нь олон улсын хэмжээнд санал болгож байгаа СНСЗ-уудыг биелүүлээд зогсохгүй эдгээрийг үндэснийхээ зорилтуудтай уялдуулах боломжтой болж байна. Монгол Улсад СНСЗ-уудыг хэрэгжүүлэх ажлын талаарх мэдээллийг “Үндэсний хэмжээнд СНСЗ-уудыг хэрэгжүүлэх хүрээ” хэмээх баримт бичигт тусгасан (www.reddplus.mn)

СНСМС-ийг боловсруулсан бусад орнууд өнөөдрийг хүртэлх хугацаанд дараах 4 гол бүрэлдэхүүн хэсгийг (Зураг 1-т харуулсан) голлон анхаарч ирснийг НҮБҮАӨСК-аас гаргасан СНСМС-ийг боловсруулах гарын авлагад⁷ онцлон тэмдэглэсэн байдаг.

⁶ UN-REDD Хөтөлбөр (2016) Сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг тухайн улсын онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх арга зам

⁷ UN-REDD Хөтөлбөр (2017), REDD+ Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн системийг төлөвлөх нь: Хураангуй гарын авлага -2.0. Женев.

Зураг 1: REDD+-ийн СНСМС-ийг боловсруулахад анхаарах гол зүйлс



Эдгээр нь Монголд СНСМС-ийн загварыг боловсруулах эхний гол алхмууд болж байна. Дээрх алхмуудыг 2017-2018 оны хооронд Монгол орны REDD+ хөтөлбөрийн түнш хамтрагч байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн СНСЗ ба СНСМС-ийн техникийн ажлын хэсгийн (СНСЗ ба СНСМС-ийн TAX) удирдлагаар шат дараалалтайгаар хэрэгжүүллээ. Хэдийгээр UN-REDD хөтөлбөрийн удирдамжийг аль болох баримтлахыг хичээсэн боловч институцийн чиг үүргийг тодорхойлоход ихээхэн анхаарал тавьсан. Учир нь СНСМС-д олон байгууллага голлох үүрэгтэй оролцох юм. Энэ хэсэгт мөн цаашид хэрэгжүүлэх алхмуудыг тайлбарласан болно. Харин 3 дугаар хэсэгт Монгол оронд анх удаа байгуулах гэж байгаа СНСМС-ийн загварын бүрэлдэхүүн хэсгүүдийг санал болгосон.

Алхам 1: СНСМС-ийн зорилгыг тодорхойлох

СНСМС-ийн үндсэн гол зорилго нь НҮБҮАӨСК-д заасны дагуу сөрөг нөлөөллөөс сэргийлэх Канкуны зарчмуудыг REDD+-ийн үйл ажиллагаанд хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэх явдал юм⁸. Үүн дээр нэмээд тухайн улс REDD+-ийн үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа бусад санхүүжүүлэгчдийн зүгээс тавьдаг шаардлагыг хангахад чиглэсэн зорилгуудыг СНСМС-д оруулж болно.

⁸ “Тусгах” гэдэг нь бодлого, хууль, журам, институц, мэдээллийн системүүдэд (цаасан дээр) СНСЗ-тай холбоотой асуудлыг хэрхэн тусгасан буюу “засаглалын зохион байгуулалт”-ыг хэлнэ. “Хэрэгжилт” гэдэг нь уг засаглалын зохион байгуулалт хэрхэн хэрэгжиж, практикт ямар бодит эерэг үр дүн гарч байгаа талаар авч үзнэ. Шигтгээ 2-ыг үз.

Алхам 2: Мэдээллийг систем ба эх үүсвэрүүдийг үнэлэх

НҮБ-ын УАӨ-ийн суурь Конвенцийн газраас гаргасан СНСМС-ийг боловсруулах удирдамжид заахдаа уг системийг байгуулахдаа аль болох одоо ашиглаж байгаа, холбогдох мэдээллийн эх үүсвэр болон системүүдэд түшиглэхийг зөвлөсөн байна. Одоогийн ашиглаж байгаа системүүдэд тулгуурлахдаа юуны өмнө тэдгээр мэдээллийн систем болон мэдээллийн эх үүсвэрүүдийн агуулга, үйл ажиллагаа тэдгээрийг ажиллуулдаг байгууллагуудын чиг үүрэг зэргийг хянаж үнэлэн, СНСМС-ийн зорилго болон гүйцэтгэх үүрэгтэй нийцэж чадах эсэхийг тогтоох ёстой. Мөн СНСМС-д мэдээлэл оруулах байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох гэрээ хийх, хяналт тавих механизм бий болгох замаар дутагдаж байгаа мэдээллийг бүрдүүлэх зэрэг институцын шинэ зохион байгуулалт хийх шаардлагатай болж болох юм.

Алхам 3: Мэдээллийн хэрэгцээ ба бүтцийг тодорхойлох

СНСМС-ийн загварыг боловсруулахдаа юуны өмнө СНСЗ-уудыг хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгааг ямар мэдээллээр харуулах шаардлагатайг тодруулах хэрэгтэй бөгөөд үүнд онцгойлон анхаарах нь зүйтэй. Мэдээллийг гол хэрэгцээг дараах алхмаар тодорхойлж болно. Үүнд:

- а) СНСЗ-уудыг үндэсний онцлогт нийцүүлж тодорхойлох,
- б) Тухайн улсын хэмжээнд СНСЗ-уудыг хэрэгжүүлэхтэй холбоотой байж болохуйц бодлого, хууль, журмуудыг үнэлэх,
- в) REDD+-ийн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх явцад гарч болох үр ашиг ба эрсдэлийн талаар ойлгож мэдэх зэрэг багтана.


Мэдээллийн хэрэгцээг тодорхойлсны дараа СНСМС-ийнхээ мэдээллийн бүтцийг тэр хэрэгцээнд тохируулж боловсруулах бөгөөд шаардлагатай бол нэмж шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж болно. Энд дурдсан “бүтэц” гэдэг нь СНСМС дэх мэдээллийг хэрхэн зохион байгуулах асуудалтай хамаатай юм бөгөөд энэ бүтэц нь цаашид мэдээллийг хэрхэн эмхэтгэх, зохион байгуулах, үнэлэх, түгээх арга замыг тодорхойлоход дөхөм болно. Үүнд одоогийн байгаа мэдээллийн систем болон эх үүсвэрүүдийг үнэлж тэдгээр нь СНСМС-ийн зорилгыг хангаж чадах эсэхийг тогтоох асуудал мөн багтана.

Алхам 4: Гүйцэтгэх үүрэг болон институцийн зохион байгуулалтыг тодорхойлох

Институцийн зохион байгуулалтыг тодорхойлох гэдэг нь СНСМС ямар үйлдэл гүйцэтгэх, энэ системийг хэн хариуцаж ажиллуулахыг зааж өгөхийг хэлнэ. Одоогийн байгаа мэдээллийн систем, эх үүсвэрүүдийг үнэлж мөн мэдээллийн хэрэгцээ, бүтцийг тодорхой болгосноор уг системийг ажиллуулахад өөр өөр байгууллагуудын зүгээс ямар үүрэг хүлээхийг даалгаж, оноож өгөх боломжтой болдог. Ингэснээр уг системийн гүйцэтгэх үүргүүдийн талаар (Зураг 2-т үзүүлсэн мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, тайлагнах, гэх мэт.) илүү тодорхой ойлголт бий болно. СНСМС-д олон байгууллага, мэдээллийн эх үүсвэрээс

мэдээлэл төвлөрүүлэх болсон тохиолдолд байгууллага хоорондын мэдээлэл гэрээ байгуулах зэрэг институцийн шинэ зохион байгуулалтыг харгалзах шаардлагатай болж болох юм. Төрийн бус байгууллагууд (тухайлбал: иргэний нийгэм, угсаатны цөөнх болон орон нутгийн иргэдийн бүлгийн г.м) болон хувийн хэвшлийнхэн нь төрийн байгууллагуудын зүгээс СНСМС-тэй холбоотой үүргээ хэрэгжүүлэхэд нь нэмэлт хүч өгч, дутагдаж байгаа чадавхыг нь бүрдүүлж өгөх зэрэг үүрэг гүйцэтгэж болох юм. Зарим шаардлагатай мэдээлэл дутагдаж байгаа тохиолдолд тэдгээр мэдээллийг цуглуулах шинэ шийдлийг бодож олох шаардлагатай болно.

Зураг 2: REDD+ -ийн СНСМС-ийн гүйцэтгэж болох үйлдлүүд



Алхам 5: Мэдээллийн системийг ажиллуулахад шаардагдах зүйлс

Мэдээллийн системийг байгуулах сүүлийн шатанд хэрэгцээг үнэлэх үүний дотор санхүүгийн болон хүний нөөцийн хэрэгцээ чадавхыг хөгжүүлэх, технологийн шаардлагуудыг үнэлэх зэрэг ажлууд багтах ба эдгээр нь эцсийн дүндээ СНСМС-ийн загварыг бодитоор хэрэгжүүлэх, мэдээллийн системийг ажиллуулахтай холбоотой юм. Одоогийн байдлаар маш цөөн орон энэ алхмаа хийж гүйцэтгээд байгаа бөгөөд СНСМС-ийг ажиллуулж эхлэхтэй холбоотой техникийн болон технологийн шаардлагуудын талаар (ж.нь, тодорхой мэргэжилтэн, тоног төхөөрөмж шаардлагатай эсэх г.м) цөөн хэдэн дэлгэрэнгүй дүн шинжилгээг хийсэн байдаг. Энэ шатанд дараах хэдэн асуудлыг авч үзэх ёстой. Үүнд:

- Мэдээллийн сангийн загвар: Өөр өөр төрлийн мэдээллийг (бичвэр болон, статистик, орон зайн мэдээ) хэрхэн нэгтгэх вэ?
- Системд тавигдах шаардлага: Системийн гүйцэтгэх үүрэг юу вэ? Энэ системийн гүйцэтгэх үүргийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд технологийн хувьд ямар шийдлүүдийг ашиглах ёстой вэ?
- Мэдээллийг хадгалах ба зохион байгуулах: Нэмэлт техник хангамж шаардлагатай юу? Уг системийг хаана байрлуулж, ажиллуулах вэ?
- Мэдээллийг түгээх шийдэл: (Хэрэв шаардлагатай бол) Ямар төрлийн цахим талбар хэрэгтэй вэ? Хэрэглэгчид ямар мэдээллийг оруулж, авч болох вэ? Зорилтот бүлгүүдэд мэдээллийг илүү хүртээмжтэй түгээхийн тулд өөр бусад сувгийг ашиглах шаардлагатай юу?
- Одоогийн байгаа мэдээллийн эх үүсвэрийн системүүдтэй холбогдох нь: Жишээлбэл: СНСМС нь REDD+-ийн хяналт ба үнэлгээний систем болон үндэсний ойн мониторингийн систем, бусад цахим хуудсуудтай яаж холбогдох вэ? гэсэн асуултууд багтана.

3. Монгол орны СНСМС-ийн загварын бүрэлдэхүүн хэсгүүд

3.1 СНСМС-ийн зорилго

Өмнөх 2-р хэсэгт тайлбарласанчлан, Монгол оронд бий болгохоор зорьж байгаа СНСМС-ийг боловсруулах эхний алхам нь уг мэдээллийн системийн зорилгыг тодорхойлох явдал байв. Юуны түрүүнд энэ системээс гарах мэдээллийг үндэсний болон олон улсын ямар тайланд ашиглаж болох талаар авч үзэх шаардлагатай юм⁹. Хамгийн гол хэрэгцээ нь НҮБ-ын УАӨ-ийн суурь конвенцийн зүгээс REDD+-ийн үр дүнд суурилсан урамшуулал авах орнуудад тавьдаг шаардлагыг биелүүлэх явдал юм. Энэ нь Канкуны зарчмуудыг REDD+-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаар

⁹ Энд “олон улсын” гэдэг нь олон талт санхүүгийн байгууллагууд болон конвенцууд юм. Тухайлбал, Дэлхийн банк, Уур амьсгалын ногоон сан, Азийн хөгжлийн банк, НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц гэх мэт.

мэдээлэл өгнө гэсэн үг (Доорх шигтгээ 2-ыг үз). Гэхдээ зарим орнууд СНСМС-д нэмэлт өөр зорилтуудыг тусгаж оруулсан байдаг. Үүнд: REDD+-ийн үйл ажиллагааг санхүүжүүлж байгаа бусад санхүүжүүлэгч хандивлагчдын шаардлагыг биелүүлэх, үр дүнд суурилсан урамшуулал авах, мөн үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байгаа зорилтуудын талаар тайлагнах зэрэгт уг СНСМС-ийг ашиглана гэсэн зорилтуудыг багтаасан байдаг.

Монгол орны СНСМС-ийн зорилгын талаар 2018 оны 3 дугаар сарын 25-28-нд зохион байгуулсан семинарын үеэр хэлэлцсэн (Уг тайлангийн 2-р бүлгийн хавсралт 3.1-ийг үз).

Шигтгээ 2. Тусгах ба хэрэгжүүлэх

СНСЗ-уудыг тусгах гэдгийг НҮБ-ын УАӨ-ийн суурь конвенцийн зүгээс тусгайлан тодорхойлоогүй. Хэдий тийм боловч, REDD+-ийн БАХ-нүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөллүүдээс сэргийлэх зарчмуудыг бодлого, хууль, журмууд (БХЖ) болон институцийн зохион байгуулалтад **тусгаж байхаар** ерөнхийдөө санал нэгдсэн байдаг.

Харин дээрх БХЖ, холбогдох үйл ажиллагаануудыг бодит байдал дээр үр дүнтэй хэрэгжүүлж, тодорхой нааштай үр өгөөж гарсан тохиолдолд сая СНСЗ-ууд **хэрэгжсэн** гэж ерөнхийд нь ойлгодог.

СНСМС-ийг REDD+ Үндэсний хөтөлбөрийн үе шатуудтай нийцүүлэн тодорхой шатлалаар байгуулах нь зүйтэй гэж санал нэгдэв. Үүнд:

1-р үе шат: 2019 – 2020

- Канкуны зарчмуудыг хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл өгөхөд
- REDD+-ээс үр дүнд суурилсан урамшуулал авах шаардлагыг хангах
- ТОТББ-ын хэрэгжилтийг дэмжих

2-р үе шат: 2021 - 2024

- Канкуны зарчмууд болон сөрөг нөлөөллөөс сэргийлэх бусад холбогдох (Уур амьсгалын ногоон сан зэрэг санхүүжүүлэгчдийн) зарчмууд мөн ойн салбартай холбоотой уур амьсгалын өөрчлөлт, түүнийг сааруулах, дасан зохицох чиглэлээр хэрэгжүүлж байгаа холбогдох бүх хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгөх (Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд Монгол Улсаас оруулах үндэсний зорилтот хувь нэмэр г.м)

Үүнээс гадна СНСМС-ийн “зорилго” хараахан биш боловч уг системийг боловсруулах явцад мөрдвөл зохих зарчмуудыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- СНСМС нь мэдээллийн хүртээмж хэрэглээг сайжруулахад дэмжлэг болохуйц байх
- СНСМС нь урт хугацаагаар тогтвортой ажиллах
- Салбар хоорондын нэгдсэн мэдээллийн систем байх
- Орон зайн дүн шинжилгээг багтаасан цахим талбар байх нь зүйтэй гэжээ.

3.2 Мэдээллийн хэрэгцээ ба бүтцийг тодорхойлох

Мэдээллийн хэрэгцээ ба бүтцийг тодорхойлох гэдэг нь СНСМС-ийн загварыг боловсруулах үйл ажиллагааны 2 дахь гол алхам байлаа. СНСМС нь Канкуны зарчмуудыг хэрхэн тусгаж хэрэгжүүлж байгаа талаар мэдээлэл өгөх үүрэгтэй байна. Энэ үйл ажиллагаа нь мэдээллийн хэрэгцээг тодорхойлох ба мэдээллийн систем болон эх үүсвэрүүдийг үнэлэх гэсэн 2 “дэд алхмаас” бүрдэнэ.

3.2.1 Мэдээллийн хэрэгцээг тодорхойлох

Холбогдох мэдээллийн төрлийг тогтоох чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл явцыг ерөнхийд нь СНСМС-ийн *мэдээллийн хэрэгцээг* тодорхойлох ажил гэж нэрлэдэг.

СНСЗ-уудыг Монгол Улсад хэрэгжүүлэх хүрээг тодорхойлох ажлын үр дүнд тулгуурлан СНСМС-ийн мэдээллийн хэрэгцээг тодорхойлж, техникийн ажлын хэсгийн саналыг авсан. Уг системд шаардлагатай мэдээллийг тодорхойлохдоо дараахыг ашигласан. Үүнд: Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлсон СНСЗ-ууд ([Англи](#), [Монгол](#)), СНСЗ-уудтай холбоотой бодлого хууль журмууд ([Англи](#), [Монгол](#)), REDD+ Үндэсний хөтөлбөрийн баримт бичгийн төсөлд тусгагдсан REDD+-ийн бодлого, арга хэмжээнүүдийг (БАХ) хэрэгжүүлэх явцад гарч болох үр ашиг ба эрсдэлийн¹⁰ үнэлгээний талаарх мэдээлэл зэрэг болно. Доор харуулсан 1-р хүснэгтэд СНСЗ-уудаас нэгийг нь буюу D зарчмыг сонгоод уг зарчимд хамаарах мэдээллийн хэрэгцээ болон шалгуур үзүүлэлтийн ямар загвартай байж болохыг харуулсан байна. Мэдээллийн хэрэгцээг бүрэн эхээр тодорхойлсон хүснэгтийг 2-р хавсралтад орууллаа.

¹⁰ Монгол Улсад хэрэгжүүлэх REDD+-ийн үйл ажиллагааны үр ашиг, эрсдэлийн үнэлгээ, 2017 оны 8 сар (Суурь тайлан англи, монгол хэлээр, Үнэлгээний хүснэгт англи, монгол хэлээр)

Хүснэгт 1: СНСЗ D-д хамаарах мэдээллийн хэрэгцээний

жишээг харуулсан нь

Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлсон СНСЗ D	Санал болгож буй мэдээллийн хэрэгцээ	Мэдээлэл цуглуулах шалгуур үзүүлэлтийн санал
D1. REDD+-ийн БАХ-нүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэх явцад оролцох талуудыг тодорхойлсон байна. Тухайн БАХ-нээс хамаараад оролцогч талууд гэдэгт орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд, ТХНЗ, усны сав газар, нөхөрлөл, иргэний нийгмийн байгууллага, холбоо, малчид, аж ахуйн нэгж болон хувийн хэвшлийн бусад байгууллагыг хамруулна. Тухайн төлөөлөн оролцогч талууд нь зохих ёсны төлөөлөл байж чадах эсэхийг холбогдох хууль, журмын дагуу тогтооно.	Тусгах: D1.1. REDD+-ийг Монголд хэрэгжүүлэхэд хамтран ажиллах талууд	Холбогдох талуудын жагсаалт (Холбогдох БХЖ, REDD+ Үндэсний хөтөлбөр, талуудын оролцооны зураглал зэрэгт үндэслэсэн байна)
	Хэрэгжүүлэх: D1.2 REDD+-н оролцогч талууд болон тэдгээрийн төлөөллийг холбогдох БХЖ-д заасны дагуу тодорхойлох үйл явцын талаарх мэдээлэл	<ul style="list-style-type: none"> • Оролцогч талуудыг хэрхэн тодорхойлсон талаарх тайлбар, тухайлбал, үйл явц, механизм г.м. Жишээ нь: <ul style="list-style-type: none"> - Холбогдох БХЖ - Оролцогч талуудын зураглал - Талуудын оролцоог хангах тухай гарын авлага - Байгууллагын чиг үүрэг

3.2.2 Мэдээллийн систем болон эх үүсвэрийн үнэлгээ

Дараагийн алхам нь одоо байгаа мэдээллийн систем ба эх үүсвэрүүдийг үнэлэх явдал байлаа. Энэ ажлыг 2018 оны 2-6 сар хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэсэн бөгөөд дараах хэсгүүдээс бүрдсэн. Үүнд:

- (i) Байж болох мэдээллийн систем ба эх үүсвэрүүдийн жагсаалтыг гаргах;
- (ii) Мэдээллийн үнэлгээ хийх маягыг REDD+-ийн сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудыг үндэсний хэмжээнд нийцүүлэн тодорхойлсон баримт бичиг дээр тулгуурлан боловсруулах;
- (iii) Холбогдох судалгааны баримт бичгийг уншиж танилцах, холбогдох байгууллагуудтай уулзах, мөн 2018 оны 3-р сард зохион байгуулсан семинарын үеэр холбогдох оролцогч талуудтай ярилцсаны үндсэн дээр уг маягыг бөглөх зэрэг ажлууд багтсан.

СНСМС-ийн мэдээллийн бүтцийг гаргахдаа үндэсний онцлогт нийцүүлж тодорхойлсон зарчмуудын элемент нэг бүрд тулгуурласан бөгөөд мэдээллийн

хэрэгцээ гэсэн хэсэгт Монгол Улс тухайн зарчмыг тусгаж, хэрэгжүүлж байгаа гэдгийг харуулахад ямар мэдээлэл шаардлагатай болохыг тодорхойлсон. Тэдгээр мэдээллийн хэрэгцээг хангах мэдээллийн эх үүсвэрүүдийг тодорхойлж, цаашид сайжруулах шаардлагатай зүйлсийг хамт оруулсан.

СНСМС нь Канкуны зарчим тус бүрийг нь хамрах ёстой учраас мэдээллийг СНСЗ тус бүрээр нь тодорхойлсон. Цаашид бий болгохоор зорьж байгаа СНСМС-д орох мэдээлэл нь үргэлжилсэн үг бичвэр, тоо мөн орон зайн судалгааны мэдээ баримт гэсэн хэлбэртэй байна. СНСЗ-уудыг үндэсний нөхцөлд нийцүүлж тайлбарлах ажлыг эцэслэн, мэдээллийн хэрэгцээг тодорхойлж, мэдээллийн олдцыг судалж үзсэний үндсэн дээр СНСЗ-уудыг хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаарх мэдээллийг цуглуулахад удирдлага болгох шалгуур үзүүлэлтүүдийн төслийг 2018 онд боловсруулав.

Сонгож авсан тодорхой СНСЗ-ийн элементтэй холбоотой мэдээллийн систем болон эх үүсвэрийн жагсаалтыг хүснэгт 2-т жишээ болгож орууллаа.

Хүснэгт 2: СНСЗ Е-д хамаарах мэдээллийн систем, мэдээллийн эх үүсвэрүүдийн үнэлгээний жишээ

Монгол орны онцлогт нийцүүлж тодорхойлсон СНСЗ	Хэрэгтэй мэдээлэл/ Мэдээллийн хэрэгцээ (хэрэгжүүлэх)	Мэдээллийн систем ба эх үүсвэр	Мэдээллийн хомсдол
ЕЗ .REDD+ БАХ-нүүд нь байгалийн ойг хамгаалах, хадгалах явдлыг урамшуулах, ой ашиглагчдын хариуцлагыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээнүүдийг илүү сонгон хэрэгжүүлж, байгалийн ойг доройтуулахаас зайлсхийх буюу эрсдэлийг бууруулна.	ЕЗ.3. REDD+-ийн хүрээнд хэрэгжиж байгаа ойг хамгаалах арга хэмжээ, ой хамгаалал болон тогтвортой ашиглалтыг дэмжсэн урамшууллын талаарх мэдээлэл	<p><u>OM7 маягтаар өгсөн ойн тооллогын мэдээ, тайлан (www.eic.mn):</u></p> <p>- OM-7 маягт нь ойд хэрэгжүүлсэн аж ахуйн арга хэмжээний хэрэгжилтийн тайланг багтаадаг. Энэ тайлан нь ойг нөхөн сэргээх, хамгаалах, сургалт сурталчилгаа явуулах, шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой орлого болон зарлагыг тайлагнадаг.</p> <p><u>Ойн бодлого зохицуулалтын газрын тайлан:</u></p> <p>- Урамшуулал хүлээж авсан аж ахуйн нэгжүүдийн тоо, урамшууллын хэмжээ</p> <p>- Улсын хэмжээнд жилд нэг удаа гардаг тайлан. Энэ нь урамшууллын журам дээр суурилсан байна.</p> <p>- Урамшууллын хэмжээ, ойн нөхөрлөлүүдийн тоо, менежментийн төлөвлөгөөний тоо, авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн тоо, менежментийн үйл ажиллагаа явуулсан ойн хэмжээ га/жилээр улсын хэмжээнд.</p> <p><u>REDD+ хяналт ба үнэлгээний тайлан</u> нь ирээдүйд олгохоор төлөвлөж байгаа урамшууллыг багтаасан байж болох юм.</p>	<p>REDD+ хяналт үнэлгээний загар хараахан бэлэн болоогүй байна.</p> <p>Хууль бус мод бэлтгэлийн талаар мэдээлсэн этгээдэд урамшуулал олгохтой холбоотой шинэ журмын хэрэгжилтэд хэрхэн мониторинг хийх вэ?</p>

	<p>Е3.4. Үндэсний REDD+ хөтөлбөрийн хүрээнд ой хамгаалах асуудлыг тусгасан БАХ-нууд болон ой хамгаалал ба тогтвортой ашиглалтыг дэмжих урамшууллыг хэрхэн хэрэгжүүлж буй талаарх мэдээлэл</p>	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын яамны ойн бодлого зохицуулалтын газраас гаргадаг <u>үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан</u></p> <p><u>ОМ маягтаас бүрдүүлдэг ойн нөөцийн мэдээллийн сан (www.eic.mn):</u></p> <p>- Тухайн жилд ойн тооллогод хамрагдсан ой бүхий газар болон ойд гарсан өөрчлөлтийн талаарх мэдээллийг аймаг болон сумын хэмжээнд боловсруулдаг. - ОМ -1 маягтаар тоон мэдээг бүрдүүлдэг, ойн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны тайлан буюу ОМ -4 маягтаар мөн тоон мэдээллийг цуглуулж авдаг. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хортон шавжаас хамгаалах, ойг нөхөн сэргээх, ойд арчилгааны огтлол хийх, ой цэвэрлэх, ой модыг огтлох, дагалдах баялгийн ашиглалт зэрэг үйл ажиллагаа багтдаг.</p> <p>Ойн судалгаа хөгжлийн төвөөс гаргадаг <u>хортон шавжтай тэмцэх талаарх ажлын мэдээлэлд</u> аймаг сумын хэмжээнд энэ чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тоог нэгтгэж жилийн тайлан болгож гаргадаг.</p> <p><u>Байгаль орчны төлөв байдлын тайлан (https://www.mne.mn/?page_id=542):</u></p> <p>- Уг тайланг 2 жилд нэг удаа гаргадаг. Ойн нөөцийн төлөв байдалтай холбоотой бүх мэдээлэл ордог. Ойн нөхөн сэргээлт болон ойг хамгаалах үйл ажиллагааны талаарх мэдээлэл мөн багтдаг.</p>	<p>Ойн нөөцөд гарч байгаа өөрчлөлтийг жил болгон тайлагнаж чаддаггүй. Ойн мэдээллийн сангийн бүртгэлийн журмаар бол ойн нөөцийн өөрчлөлтийн талаарх мэдээллийг ОМ-2 тайланд жил бүр оруулах ёстой байдаг боловч сумын түвшинд чад авах хангалтгүй байгаагаас энэ үйл ажиллагааг журмын дагуу явуулж чадахгүй байна.</p>
--	---	---	---

Цаашид СНСМС-д дараах 2 гол төрлийн мэдээлэл оруулна гэж тодорхойлов:

- (i) *СНСЗ-уудыг үндэсний хэмжээнд бодлого, хууль, журмуудад (БХЖ) хэрхэн тусгаж байгаа талаарх мэдээлэл.* СНСЗ-уудыг Монголд тусгаж, хэрэгжүүлэхтэй холбоотой гэж үзсэн БХЖ-ууд үүнд багтана. Тухайлбал, одоогийн мөрдөж байгаа БХЖ-ууд, Канкуны зарчмуудыг хангахад хувь нэмэр оруулах зүйл, заалт зэргийг дурдана. Мөн СНСМС-д оруулах шаардлагатай боловч олоход хүндрэлтэй мэдээллийг тодорхойлж, холбогдох хууль журмын хүрээнд энэ мэдээллийг бүрдүүлэх талаар ямар арга хэмжээ авч болохыг тодорхойлсон байна. Үүнээс гадна СНСЗ-уудыг тусгахтай холбоотой REDD+-ийн тусгай үйл ажиллагааны талаарх мэдээллийг энд оруулна.
- (ii) *Үндэсний болон аймгийн хэмжээнд СНСЗ-уудыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх мэдээлэл.* Энэ мэдээлэл нь СНСЗ-уудтай холбоотой БХЖ-ууд, үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжүүлсэн REDD+ -

ийн үйл ажиллагаанаас гарах үр дүн болон ойн арга хэмжээнд хяналт тавихтай холбоотой одоогийн мэдээллийн эх үүсвэрүүд, түүнчлэн ирээдүйд бий болох эх үүсвэрүүдтэй холбоотой байх юм. Энэ төрөлд хамаарах мэдээлэл нь БХЖ амьдралд хэрхэн хэрэгжиж байгаа талаарх бичвэр болон статистик мэдээллээс (жишээ нь, улсын байгууллагаас гаргасан тодорхой бодлого хууль журмын талаарх тайлан, холбогдох мэдээллийн сан гэх мэт) бүрдэхээс гадна тэдгээрийн хэрэгжилтийг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг мөн агуулсан байна. Энэ хэсэгт үндэсний REDD+ хөтөлбөрийн хяналтын үйл ажиллагааны үеэр цуглуулсан нэмэлт мэдээллийг оруулж болно (жишээ нь, үйл ажиллагаанд талуудын оролцоог хангах, REDD+-ийн үр ашиг ба урамшууллыг тэгш хүртээх талаар хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа гэх мэт).

Мэдээллийн системүүд болон эх үүсвэрүүдэд үнэлгээ хийсний үндсэн дээр СНСЗ-уудын хэрэгжилттэй холбоотой мэдээллийг авч болох гол эх үүсвэрүүдийг олж тогтоосныг доор (хүснэгт 3-т) үзүүлэв.

Хүснэгт 3: СНСЗ-тай холбоотой гол мэдээллийн систем ба эх үүсвэрүүд

СНСЗ	Холбогдох гол мэдээллийн систем
А	Ой, биологийн олон янз байдал, тусгай хамгаалалттай газар, цөлжилтэй тэмцэх, ус хамгаалах, хүнсний аюулгүй байдал, хүний эрх, уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр хэрэгжиж байгаа үндэсний бодлого, хөтөлбөрүүдийн тайлан Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийн үндэсний мэдээллийн сан (ТХЗ) Монгол орны REDD+ хөтөлбөрийн баримт бичгүүд
В	Байгаль орчны мэдээллийн төвийн мэдээллийн сан: <ul style="list-style-type: none"> ○ Байгаль орчны байгууллага болон ажилтнуудын мэдээллийн сан ○ Ойн мэдээллийн сан Ойн судалгаа хөгжлийн төвөөс гаргадаг үндэсний ойн тооллого болон ойн зохион байгуулалтын мэдээ Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас Засгийн газрын хэрэг эрхлэх газарт гаргаж өгдөг байгаль орчны хууль эрх зүйн хэрэгжилтийн тайлан Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас гаргадаг байгаль орчны хууль эрх зүйн зөрчлийн талаарх тайлан Шилэн дансны тайлан Ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааны жилийн тайлан REDD+ Үндэсний хөтөлбөрийн баримт бичиг, хяналтын тайлан
С	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын (ГЗБГЗЗГ)-ын газрын менежментийн мэдээллийн сан ГЗБГЗЗГ-аас гаргадаг нүүлгэн/ шилжүүлэлт, газрыг чөлөөлөхтэй холбоотой нөхөн төлбөрийн мэдээллийн тайлан,

	<p>Нийслэл, сум, дүүргийн газрын менежментийн төлөвлөгөө (жил тутамд)</p> <p>Үндэсний хүний эрхийн комиссоос жил бүр гаргадаг тайлан</p> <p>REDD+ Үндэсний хөтөлбөрийн баримт бичиг, хяналтын тайлан</p>
D	<p>Байгаль орчны мэдээллийн сан:</p> <ul style="list-style-type: none"> ○ Байгаль орчны байгууллага болон ажилтнуудын мэдээллийн сан ○ Байгаль орчин хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа олон нийтийн байгууллагуудын мэдээллийн сан <p>Хүний эрхийн комиссын жилийн тайлан</p> <p>REDD+ Үндэсний хөтөлбөрийн баримт бичиг, хяналтын тайлан</p>
E	<p>Байгаль орчны мэдээллийн сан:</p> <ul style="list-style-type: none"> ○ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн сан ○ Ойн мэдээллийн сан ○ Усны нөөцийн мэдээллийн сан ○ Газрын доройтлын талаарх мэдээллийн сан <p>ГЗБГЗЗГ-аас гаргадаг нүүлгэн/ шилжүүлэлт, газрыг чөлөөлөхтэй холбоотой нөхөн төлбөрийн мэдээллийн тайлан,</p> <p>Ойн судалгаа, хөгжлийн төвийн мэдээллийн сан:</p> <ul style="list-style-type: none"> ○ Үндэсний ойн тооллогын мэдээллийн сан ○ Ойн зохион байгуулалтын мэдээ ○ Ойн дагалт баялгийн талаарх тайлан <p>Ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагааны жилийн тайлан</p> <p>Монгол орны REDD+ хөтөлбөрийн баримт бичиг, хяналтын тайлан</p> <p>Үндэсний ойн мониторингийн систем (YOMC)</p>
F	<p>ГЗБГЗЗГ-аас гаргадаг бэлчээрийн даацын зураг</p> <p>Байгаль орчны мэдээллийн сан :</p> <ul style="list-style-type: none"> ○ Ойн мэдээллийн сан ○ Газрын доройтлын талаарх мэдээллийн сан <p>Ойн судалгаа хөгжлийн төвийн мэдээллийн сан:</p> <ul style="list-style-type: none"> ○ Үндэсний ойн тооллогын мэдээллийн сан ○ Ойн зохион байгуулалтын мэдээ <p>Монгол орны REDD+ хөтөлбөрийн баримт бичиг, хяналтын тайлан</p> <p>Үндэсний ойн мониторингийн систем (YOMC)</p>
G	<p>Байгаль орчны мэдээллийн сан :</p> <ul style="list-style-type: none"> ○ Ойн мэдээллийн сан <p>Ойн судалгаа хөгжлийн мэдээллийн сан:</p> <ul style="list-style-type: none"> ○ Үндэсний ойн тооллогын мэдээллийн сан ○ Ойн зохион байгуулалтын мэдээ <p>Монгол орны REDD+ хөтөлбөрийн баримт бичиг, хяналтын тайлан</p> <p>Үндэсний ойн мониторингийн систем (YOMC)</p>

Мэдээллийн систем болон мэдээллийн эх үүсвэрүүдийн үнэлгээг хийснээр шаардлагатай мэдээллийг олж болох ямар эх үүсвэрүүд байгаа талаар тодорхой ойлголттой болсон. Хэдий тийм боловч, зарим шаардлагатай мэдээллийг бүрдүүлж чадахгүй байх, мэдээлэл дутагдах явдал байсаар байна. REDD+-ийн ҮОМС-ийн загварыг бүрэн ажиллуулж эхэлсний дараа ойн нөөцтэй холбоотой мэдээллийн дутагдалтай байдлыг шийдвэрлэж болох юм. ҮОМС нь ГЗБГЗЗГ болон ОСХТ-өөс гаргадаг мэдээллийг нэгтгэж өгөхийн зэрэгцээ СНСЗ E,F,G-тэй холбоотой мэдээллийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Зарим мэдээллийг бүрдүүлэхийн тулд тодорхой өөр арга хэмжээ авах шаардлагатай болно. Жишээлбэл, бидний энэ үнэлгээний явцад олж авсан мэдээллийн эх үүсвэрүүдийн нэлээд хэсэг нь тогтмол шинэчлэгддэггүй бөгөөд энэ нь хүний нөөц дутагдалтай байгаатай холбоотой. Үүнээс гадна зарим чухал тайлан тухайлбал улсын мэргэжлийн хяналтын газраас гаргадаг тайланг олон нийтэд нээлттэй танилцуулдаггүй. Өөр нэг тулгарч байгаа бэрхшээл нь маш олон тайлан тухайлбал, ойн менежментийн төлөвлөгөө зэрэг нь зөвхөн цаасан дээр хэвлэгддэг бөгөөд тэдгээр тайланг онлайн системд амар хялбар оруулах боломжгүй байгаа явдал юм. Эцэст нь хэлэхэд, одоогоор гарч байгаа ихэнх тайлан нь тодорхой нэг салбарт чиглэсэн байх бөгөөд салбар хоорондын мэдээлэл солилцох хуваалцах механизм дутагдалтай байгаа.

3.3 СНСМС-ийн институцийн зохион байгуулалт

2018 оны 3-р сард зохион байгуулсан СНСМС-ийн загварыг боловсруулах семинарын үеэр оролцогчид Монголд байгуулах СНСМС-ийг ажиллуулах институцийн зохион байгуулалт, холбогдох байгууллагуудын үүрэг хариуцлага ямар байх талаар хэлэлцсэн (Хавсралт 3.1). UN-REDD Хөтөлбөрийн удирдамжид СНСМС-ийн гүйцэтгэж болох чиг үүргүүдийг ерөнхий байдлаар зурагласныг авч оролцогчдод танилцуулсан бөгөөд энэ жагсаалтыг оролцогчид улам баяжуулж, СНСМС-ийн үйл ажиллагаанд оролцвол зохих гол байгууллагуудыг тодорхойлж, тэдгээр байгууллага ямар чиг үүрэгтэй оролцох талаар санал боловсруулсан. Мөн СНСМС-д оролцох байгууллагуудын институцийн зохион байгуулалт, бүтцийн тойм зураглалыг энэ семинарын үеэр боловсруулсан.

Дээрх семинарын үеэр гарсан санал болон хэлэлцүүлгийн үр дүнг СНСМС ба СНСЗ-ийг боловсруулах техникийн ажлын хэсгийн хурлаар дахин авч хэлэлцээд уг системийг боловсруулахад анхаарвал зохих хамгийн бодитой хувилбаруудыг гаргаж ирсэн бөгөөд СНСМС-ийг Байгаль орчны мэдээллийн төв (БОМТ) дээр байршуулах нь зүйтэй гэсэн хувилбарыг онцолж үзсэн¹¹. Үүний дараа дахин Улаанбаатар хотноо 2018 оны 5 сард цөөн хүнтэй ажлын хэсгийн уулзалтыг зохион байгуулж институцийн зохион байгуулалтын талаар нарийвчлан хэлэлцэв.

¹¹ БОАЖЯ-ны харьяа, Ус цаг уур, орчны судалгааны хүрээлэнгийн мэдээллийн алба (УЦУОСХ)

2018 оны 6 сард Улаанбаатар хотноо зохиогдсон СНСМС-ийн загвар боловсруулах асуудлаарх семинарын үеэр дээрх институцийн зохион байгуулалтын талаар хэлэлцсэн бөгөөд энэ үеэр СНСМС-ийг ажиллуулахад зүйлсийн талаар түлхүү анхаарч ажилласан (Тайлангийн 2-р бүлгийн Хавсралт 3.2, 3.3-ыг үз). СНСМС-ийн институцийн зохион байгуулалтын талаарх саналыг дор нэгтгэн орууллаа.

Хүснэгт 4: Байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хариуцлага

Энэ хүснэгтэд СНСМС-ийн гүйцэтгэх үүрэг тухайлбал мэдээллийг нэгтгэх тайлан боловсруулах, зэрэг үүрэг болон эдгээр үүргийг гүйцэтгэх магадлалтай байгууллагуудыг жагсаасан болно.

Байгууллага	СНСМС –ийг ажиллуулах чиглэлээр гүйцэтгэх үүрэг	Холбогдох чиг үүрэг, чадавх бусад
Ойн судалгаа, хөгжлийн төв (ОСХТ)	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн зарчимтай холбоотой ойн салбарын мэдээллийг цуглуулж оруулж шинэчлэх ба мэдээллийг дүгнэн шинжлэх хянах	Ойн салбарын бүх мэдээг нэгтгэх дүн шинжилгээ хийх хянах
ГЗБГЗЗГ	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх мэдээллийн зарчимтай холбоотой газрын сангийн талаарх мэдээллийг цуглуулах, оруулах, хянах дүн шинжилгээ хийх	Газрын менежменттэй холбоотой бүх мэдээллийг эмхтгэх, дүн шинжилгээ хийх хянах
Үндэсний статистикийн хороо (ҮСХ)	Сөрөг нөлөөллөөс сэргийлэх зарчмуудтай холбоотой нийгэм эдийн засаг болон тогтвортой хөгжлийн хүчин зүйлсийн талаарх мэдээллийг цуглуулах, оруулах, шинэчлэх үүрэг гүйцэтгэнэ. СНСЗ-уудтай холбоотой мэдээллийг боловсруулж хэвлэх, олон нийтэд тараах үүрэг хүлээх болно.	Мэдээллийг цуглуулах эмхтгэх түгээх зэрэг ажил нь ҮСХ-ийн гол үндсэн чиг үүрэгт хамаарах бөгөөд мэдээлэл цуглуулах, загвар аргачлалыг батлах талаар хариуцдаг.
Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)	Холбогдох мэдээллийг цуглуулах, оруулах, шинэчлэх, дүн шинжилгээ хийх хянах	Байгалийн гамшгийн талаар мэдээлэл өгч хяналт үнэлгээ явуулж, мэдээллийн хэрэгслээр байгалийн гамшигт үзэгдэл онцгой байдлын талаар олон нийтэд сэрэмжлүүлэг (гал түймэр г.м) өгдөг.
Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар (МХЕГ)	Холбогдох мэдээллийг цуглуулах, оруулах, шинжлэх, дүн шинжилгээ хийх, хянах	Хуулийн хэрэгжилтийн талаар хяналт тавих, мэдээлэлд дүн шинжилгээ хийж дээрх мэдээллийг олон нийтэд түгээх үүрэгтэй.
Сангийн яам	Төсвийг бүрдүүлж хуваарилах санхүүгийн талаарх мэдээллийг гаргах үүрэгтэй. (бодлого арга хэмжээтэй холбоотой)	Улсын хэмжээнд төсөв хуваарилах үүрэгтэй.
Цагдаагийн ерөнхий газар	Холбогдох мэдээллийг цуглуулах оруулах дүн шинжилгээ хийх, хянах	Гэмт хэргийн талаарх мэдээллүүдийг бүрдүүлдэг. Үүнд: байгаль орчны эсрэг гэмт хэрэг орно. Хяналт тавьж, онлайн мэдээллийн системээр дамжуулж мэдээллийг олон нийтэд түгээдэг.
Үндэсний хөгжлийн газар	Салбар дундын хамтын ажиллагааны талаар мэдээллийг цуглуулах, түгээх үүрэгтэй	Үндэсний хэмжээнд бодлого хөтөлбөрүүдийг нэгтгэх уялдуулах,

		үүрэгтэй
Байгаль орчны мэдээллийн төв (EIC)	Холбогдох мэдээллийн сангуудаас байгаль орчны талаарх мэдээллийг гаргаж өгөх, мэдээллийг нэгтгэх түгээх, СНСМС-ийг ажиллуулах тогтвортой ажиллагааг нь хангах, мэдээлэл цуглуулах, оруулах ажлыг чиглүүлэх	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 37-р зүйлд заасан байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй байдаг.
Хүний эрхийн үндэсний хороо	Хүний эрхтэй холбоотой мэдээллийг цуглуулах, системд оруулах шинэчлэх дүн шинжилгээ хийх хянах	Хүний эрхтэй холбоотой мэдээлэлд хяналт мониторинг хийх, олон нийтээс хүлээж авсан санал гомдол түүнийг шийдвэрлэсэн байдлын талаарх тоо зэргийг олон нийтэд нээлттэй зарласан байдаг. (хувь хүний мэдээллийг нууцалдаг)
Ойн тогтвортой хөгжлийн зөвлөл болон байгаль орчны иргэний зөвлөл	Чанарын хяналт тавих, мэдээллийг нягтлах	Байгаль орчны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг цуглуулж, түүнд хяналт тавих зөвлөмж гаргах
Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого зохицуулалтын газар	СНСМС-ийн санхүүжилтэд хяналт тавих, НҮБУАӨСК-д хүргүүлэх тайлан (SOI) боловсруулах, тайланг батлах, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй.	Ойн хууль болон бодлогын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх
Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэх нэгж, эсвэл БОАЖЯ-ын УАӨГХАГ	НҮБУАӨСК-д Тайлан /SOI/ хүргүүлэх	Уур амьсгалын өөрчлөлтийн төсөл хэрэгжүүлэх нэгж, НҮБУАӨСК-ийн хүрээнд хүлээсэн үүрэг амлалтыг хэрэгжүүлэх үүрэгтэй. БОАЖЯ-ны УАӨГХАГ нь тайланг илгээхээс өмнө шалгах үүрэгтэй.

Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс СНСМС-ийг ажиллуулахад ямар үүрэг гүйцэтгэж болох талаар бид мөн холбогдох талуудтай ярилцсан. Дараах хүснэгтэд иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэж болох үүргүүдийг жагсааж орууллаа.

Хүснэгт 5. Иргэний нийгмийн болон бусад байгууллагуудын зүгээс СНСМС-ийг ажиллуулахад гүйцэтгэж болох үүргийг санал болгосон нь

Мэдээлэл нийлүүлэх, цуглуулах, өгөх	Мэдээлэл дүн шинжилгээ хийх, хянах	Мэдээллийг түгээх	Бусад үүрэг
СНСЗ-уудтай холбогдож болох мэдээллийг цуглуулдаг олон байгууллага байна. Тухайлбал: - Монголын байгаль орчны иргэний зөвлөл (МБОИЗ)	Иргэний нийгмийн байгууллагууд нь дараах чиглэлээр мэдээлэл дүн шинжилгээ хийх,	Ой болон байгаль орчны талаар мэдээлэл хүлээн авч олон нийтэд түгээдэг иргэний нийгмийн	Иргэний нийгмийн байгууллагууд нь СНСМС болон СНСЗ-уудтай холбоотой дараах

<p>- Иргэний нийгмийн хүний эрхийн форумын гишүүн байгууллагууд</p> <p>- Мэргэшсэн төрийн бус байгууллагууд болон олон улсын байгууллагууд (Байгаль хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд)</p> <p>- Орон нутгийн төрийн бус байгууллагууд</p> <p>- Ой болон байгалийн нөөц ашиглагчдын бүлэг, иргэд, хувь хүмүүс</p> <p>Эдгээр байгууллага, бүлгүүд нь холбогдох мэдээллийг орон нутгийн түвшинд цуглуулдаг боловч эдгээр мэдээллийг тэр бүр тогтмол цуглуулж чаддаггүй ба мэдээллийг онлайнар түгээдэг. Дараах чиглэлээр мэдээлэл цуглуулдаг.</p> <ul style="list-style-type: none"> - Байгаль орчны доройтол (Уул уурхай нөхөн сэргээлтийн байдал) - Байгаль орчны хуулийн зөрчил - Байгалийн гамшиг <p>Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн цахим хуудас болон утсаар хууль бус үйл ажиллагааны талаар мэдээллүүдийг иргэд, олон нийтээс их авдаг бөгөөд үүнийгээ жилд нэг удаа тайлан болгож БОАЖЯ-аманд хүргүүлдэг. Хэдий тийм боловч иргэд болон төрийн бус байгууллагууд эдгээр мэдээллийг хэнд хүргэх талаар сайн мэдэхгүй байгаа нь ажиглагдаж байна.</p> <p>Монголын байгаль орчны иргэний зөвлөл нь 21 аймагт салбартай бөгөөд өөрсдийн цахим хуудсаа тогтмол ажиллуулах, мэдээлэл түгээх тал дээр санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал дутмаг байна.</p> <p>Оролцогч талуудаас иргэний нийгмийн байгууллагууд болон орон нутгийн иргэдийг мониторинг, хяналтын ажилд оролцуулах нь зөрчил, бусад</p>	<p>нягтлах ажлыг хийж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Монголын иргэний нийгмийн зөвлөлийн гишүүн байгууллагууд болон зарим мэргэшсэн төрийн бус байгууллагууд нь тайлан эмхэтгэх, БОАЖ-ийн яаманд зөвлөмж өгөх чиглэлээр ажиллаж байна. - Нээлттэй нийгмийн хүний эрхийн форумын гишүүн байгууллагууд нь хүний эрхийн талаар тогтмол тайлан хэвлэж гаргадаг. (НҮБ-ын конвенцууд) <p>Эдгээр байгууллагууд нь энэ ажлаа үргэлжлүүлэн СНСМС-д мэдээлэл оруулж өгч болох бөгөөд нээлттэй нийгмийн форумын гишүүд нь хүний эрхийн талаарх тайлан гаргаж болно. Үүнээс гадна, нутгийн иргэд, ойн нөхөрлөл, ойн аж ахуйн нэгжүүд нь СНСЗ болон СНСМС-ийн мэдээллийг хянаж нягтлахад тодорхой үүрэг гүйцэтгэж болно.</p> <p>Төслийн хэрэгжилтэд хяналт буюу мониторинг хийх ажлыг байгаль орчны иргэний зөвлөлийн гишүүн байгууллагуудаар (одоогоор маш цөөхөн төрийн бус байгууллага энэ чиглэлээр ажиллаж байгаа) түлхүү хийлгэх нь зүйтэй. Орон нутгийн болон</p>	<p>байгууллагууд байдаг (жишээ нь, МБОИЗ). СНСМС-тэй холбоотой мэдээллийг түгээх чиг үүргийг хэн хариуцах талаар талуудаас тодорхой санал гараагүй байна.</p> <p>СНСЗ-тай холбоотой мэдээллийг хүлээн авч, оруулдаг цахим хуудас, тусгай утас ажиллуулах шаардлагатай гэж зөвлөв. Малчид болон орон нутгийн иргэд нь мэдээллээ бичгээр илгээх боломжтой байхаар зохион байгуулах нь зүйтэй. Мэдээлэл өгөх, илгээх арга нь ойлгомжтой, хялбар байх шаардлагатай.</p>	<p>үүргийг гүйцэтгэж болно гэж үзжээ.</p> <ul style="list-style-type: none"> - СНСЗ-уудыг хэрэгжүүлсэн төрийн бус байгууллага болон хувь хүмүүст урамшуулал олгох. <p>Жишээлбэл: байгаль орчны чиглэлээр амжилттай ажилласан ойн нөхөрлөлүүдэд, усны нөөцийг бий болгосон, хамгаалсан байгууллага, бэлчээр хамгаалах, байгаль орчныг хамгаалахтай, холбоотой хүмүүсийн зан байдлыг өөрчлөх чиглэлээр санаачилга гаргасан байгууллагуудад г.м)</p> <p>Дээр дурдсан үйл ажиллагаануудыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлж болно.</p> <ol style="list-style-type: none"> 1) Байгалийн нөөцийн төлбөрөөс, 2) Дотоодын болон олон улсын төсөл хөтөлбөрүүдээс
--	--	---	--

<p>сөрөг нөлөөллийг эрт илрүүлэхэд тустай гэж үзсэн. Иргэний нийгмийн байгууллагууд болон орон нутгийн хяналт тавих үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр хөрөнгө төсөв хуваарилах шаардлагатай бөгөөд үүнийг хууль бус үйл ажиллагаанд оноосон торгуулийн хураамжаас бүрдүүлж болно гэж зөвлөсөн. (Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 43-р зүйл).</p>	<p>байгаль орчны төрийн бус байгууллагууд БОАЖЯ-нд энэ чиглэлийн тайлан өгдөг бөгөөд тайландаа холбогдох мэдээг хавсаргаж өгдөг (бохирдол, байгаль орчны хууль зөрчсөн үйл ажиллагаа г.м) СНСЗ-уудыг хэрхэн тусгаж, хэрэгжүүлж байгаа талаар хяналт тавих, тайлагнах ажлыг хийж болно.</p> <p>Иргэний нийгмийн байгууллагуудаар хяналтын ажил хийлгэх бол төсөв хуваарилж, дэмжлэг үзүүлэх шаардлагатай. (Байгаль хамгаалах сангаас)</p>		
--	--	--	--

Доорх бүдүүвч зурагт, СНСМС-ийг ажиллуулахтай холбоотой институцийн зохион байгуулалтыг харуулсан бөгөөд үүнд ямар байгууллага, ямар үүрэг гүйцэтгэж болох, тэдгээр хоорондоо хэрхэн уялдаж байх талаар санал болгов.

Зураг 3: СНСМС-ийг ажиллуулах институцийн зохион байгуулалтыг

санал болгосон нь



3.4 СНСМС-ийг байгуулах арга барил

СНСМС-ийг байгуулахад уг системийн үйлдэл, технологийн шаардлагууд нь ямар байх талаар оролцогч талуудтай хэд хэдэн удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулсны үндсэн дээр Монголын нөхцөлд СНСМС нь хоёр үндсэн хэсэгтэй байх нь зүйтэй гэсэн санал дэвшүүлж байна. Үүнд СНСМС-ийн мэдээллийн сан, олон нийтэд мэдээллийг харуулах онлайн вэб хуудас гэсэн гэсэн багтана. Олон нийтэд мэдээлэл түгээдэг онлайн вэб хуудсыг Монголд түгээмэл ашигладаг. Тухайлбал, БОМТ (www.eic.mn), Үндэсний статистикийн газрын ТХЗ-уудын талаарх мэдээлэл бүхий цахим хуудас (<http://sdg.1212.mn>) зэрэг олон цахим хуудас бий. Хэдий тийм боловч, REDD+ болон СНСЗ-уудын талаарх мэдээллийг түгээхэд, тэр дундаа алслагдсан орон нутгийн иргэдэд энэ талаар мэдээлэл хүргэхийн тулд өөр бусад мэдээллийн сувгийг ашиглах шаардлагатай юм. Онлайн мэдээллийн сан байгуулахаас өмнө, REDD+ Үндэсний хөтөлбөрийн хүрээнд эксел хүснэгтэд суурилсан СНСМС-ийн хувилбарыг ашиглаж болох юм.

3.4.1 Мэдээллийн системийн загвар буюу бүтэц: тодорхой шатлалтайгаар хөгжүүлэх нэгдсэн системийн арга

Өмнөх 3.1 дэх хэсэгт дурдсанчлан СНСМС-ийн онлайн мэдээллийн сан болон интерфэйсийг тодорхой үе шаттайгаар байгуулах бөгөөд энэ нь одоогийн байгаа БОМТ-ийн мэдээллийн санд суурилсан байна. Доор харуулсан Зураг 4-т энэхүү нэгдсэн системийн ерөнхий бүтэц ямар байхыг санал болгожээ. Нэгдсэн системийн гол онцлог нь:

- СНСМС-ийн мэдээллийн санг эксел дээр боловсруулаад дараа нь (байгууллагын чиг үүрэгт нь тусгагдаж, батлагдан, жилийн ажлын төлөвлөгөөнд нь орсны дараа) БОМТ-ийн сервер дээр байршуулна. Зарим шалгуур үзүүлэлтүүдэд тохирох мэдээллийг өөр цахим мэдээллийн сангуудаас авах шаардлагатай болдог. Тийм шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлно. Эдгээр гол цахим мэдээллийн сан гэдэгт БОМТ-ийн одоо байгаа мэдээллийн сангууд тухайлбал, ойн мэдээллийн сан, усны нөөцийн мэдээллийн сан, газрын мэдээллийн сан мөн ҮСХ-ны цахим мэдээллийн сангууд (тухайлбал, нийгэм эдийн засгийн статистик, тогтвортой хөгжлийн зорилтуудын мэдээллийн сан гэх мэт), ГЗБГЗЗГ-ын газар зохион байгуулалтын мэдээллийн сан зэрэг багтана. ҮОМС мөн энэ ангилалд багтана.
- Холбогдох мэдээллийг тодорхойлсны дараа тэр мэдээллийг татаж авч СНСМС рүү оруулахад ашиглах кодыг боловсруулах ба энэ кодоор тухайн мэдээллийг СНСМС-ийн бүтцэд оруулж, харгалзах шалгуур үзүүлэлтийнх нь дагуу байрлуулна. Юуны түрүүнд нэн тэргүүний шалгуур үзүүлэлтүүдээ сонгож аваад тэдгээрт хамаарах, албан ёсны баттай гэж үзсэн мэдээллүүдээ оруулж эхлэх нь зүйтэй.
- Өөр бусад эх үүсвэрээс, тэр дундаа одоогоор цахим хэлбэрээр байршуулаагүй байгаа мэдээллийг шаардах шалгуур үзүүлэлтүүдийг мөн тодорхойлж тэдгээрийг цуглуулах маягтуудыг нь бүрдүүлнэ.¹² СНСМС-ийн админ руу шаардлагатай мэдээллийг бөглөж илгээхэд ашиглах тусгай маягтуудыг шинээр боловсруулж, холбогдох байгууллагуудад өгнө. Ийм хэлбэрээр мэдээлэл нийлүүлэх байгууллагуудын тоонд ОБЕГ, МХЕГ, аймаг сумын ойн ангиуд орно.
- СНСМС-д орох нэмэлт мэдээллүүдийг (ялангуяа уг системийн эхний интерфэйсд хэрэг болох) бодлого, хууль тогтоомжууд, REDD+-ийн баримт бичиг (үндэсний хөтөлбөрийн баримт бичиг, үр ашиг эрсдэлийн шинжилгээ гэх мэт) болон бусад тайлангуудаас авна. Тэдгээр текст мэдээллийг сонгож авч, СНСМС-ийн эхний хувилбар луу оруулна. Цаашид мэдээлэл вэбсайтын зохион байгуулалтын систем дотроо шууд шинэчлэгддэг болно.
- The СНСМС-ийг жил бүр шинэчилж байна. Гэхдээ энэ нь тухайн мэдээллийн эх үүсвэрээс хамаарна. Жишээлбэл: ойн мэдээллийг жил тутам оруулдаг байхад ҮОМС-ээс гарах хүлэмжийн хийн ялгарлын тайлан, мэдээ 2 жил тутамд нэг удаа гардаг байх магадлалтай.
- СНСМС-ийг бүхэлд нь хамарсан, эсвэл уг системийн тодорхой бүрэлдэхүүн хэсэгт тусгайлан зориулсан вэб хуудас (СНСЗ-ын тайлан /SOI/, мэдээлэл зохион байгуулах тусгай талбар буюу дашбоард) боловсруулж болно. Энгийн бөгөөд ашиглахад хялбархан вэбсайтын платформууд олон байдаг бөгөөд одоогоор БОМТ олон нийтэд зориулсан маш их мэдээлэл бүхий мэдээллийн сангуудыг өөрийн платформдоо агуулж байгаа. Энэ вэб хуудсыг яг хаана байршуулах эсэх нь үндэсний REDD+-ийн

¹² Жишээлбэл ойн салбарт “ОМ” маягтаар ойн мэдээллийг цуглуулдаг бол ГЗБГЗЗГ нь “ГТ” маягыг ашигладаг. Эдгээр маягыг орон нутгийн түвшинд холбогдох харьяа газрын ажилтнууд ихэвчлэн бөглөдөг.

вэб хуудсыг цаашид яаж зохион байгуулахаас ихээхэн хамаарна. Цахим хуудасны онцлогуудын талаар хэлэлцсэнийг доор үзүүлсэн Шигтгээ 3-т орууллаа.


- Мэдээллийн санг боловсруулж байх явцад БОМТ-ийн платформ дээр мэдээллийн сан үүсгэх тухай тусгай журмыг, хэрэглэгчид зориулсан гарын авлагын хамт боловсруулна. Үүнд: мэдээллийн сангийн бүтэц, мэдээллийн санг ажиллуулах, мэдээллийг нь шинэчлэх, шинэ үзүүлэлт нэмэх, мөн уг мэдээллийн сангийн агуулгын менежментийн системтэй холбоотой асуудал зэргийг багтаасан байна. Мөн танилцуулах сургалт явуулна.
- СНСМС-ээс гарах мэдээллийг төрөл бүрийн тайлан боловсруулахад ашиглаж болно. СНСМС-ийг ажиллуулахаас илүүтэй тайланд дүн шинжилгээ хийх, эмхэтгэх ажлыг хийхэд хүн хүч илүү их шаардана. СНСМС-ийн мэдээллийг дараах тайлан, мэдээнд ашиглаж болно гэж оролцогч талууд үзсэн болно. Үүнд: REDD+-ийн үйл ажиллагааны талаар тайлан, БОАЖЯ-аас 2 жил тутамд нэг удаа гардаг “Байгаль орчны төлөв байдлын тайлан”¹³, НҮБ-ын УАӨСК-д хүргүүлэх, СНСЗ-уудын хэрэгжилтийн талаарх тайлан (SOI) зэрэг болно.
- Хэрэглэгчийн онцлогоос шалтгаалаад энэ мэдээллийн санд хэд хэдэн түвшинд нэвтэрч болохуйц байхаар зохион байгуулж болох юм. Мэдээллийн системийн загварыг хэрхэн сонгосноос шалтгаалаад мэдээлэл нийлүүлэгч болон хэрэглэгчдэд нэвтрэх эрх олгож, мэдээ оруулах, мэдээг шинэчлэх боломжийг хангаж өгнө.
- СНСМС-ийн энэ загварыг ажиллуулахад шаардагдах зүйлсийг 4-р хэсэгт дэлгэрэнгүй үзүүлсэн. Нэн тэргүүн шаардлагатай нь байгаль орчны мэдээллийн төвийн сервер дээр бага хэмжээний зай гаргаж өгөх, СНСМС-ийн үйл ажиллагааг хариуцах нэг ажилтныг БОМТ дээр томилох шаардлагатай. Мөн СНСМС-ийг хариуцсан нэг админ ажилтныг БОАЖЯ-нд томилж ажиллуулан уг системийн агуулга болон тайлан боловсруулах үүргийг хүлээлгэх нь зүйтэй.

Энэхүү нэгдсэн системийн арга барил нь давуу болон сул талуудтай. Монгол орны хувьд нэгдсэн систем гэдэг бол шинэлэг зүйл бөгөөд тус улсад байгаа ихэнх мэдээллийн системүүдэд мэдээлэл оруулахдаа тусгай маягтаар эсвэл гараар мэдээллийг шивэх буюу бөглөсөн маягтыг мэдээллийн санд хүний оролцоотойгоор оруулдаг. Нэгдсэн системийг ажиллуулахад мэдээллийн технологийн шийдлүүдийг ашиглах шаардлагатай. Хэдий тийм боловч нэгдсэн системтэй байснаар бусад мэдээллийн сангуудтай холбогдож, тэдгээр санд байгаа мэдээлэл нь шинэчлэгдмэгц СНСМС автоматаар шинэчлэгдэж байдаг. Энэ нь СНСМС-ийг ажиллуулах ажлын ачааллыг бууруулна. ҮОМС-д бас ийм аргачлалыг авч үзэж байгаа бөгөөд уг систем нь ГЗБГЗЗГ-ын мэдээллийн сангаас мэдээллээ шууд авч БОМТ дээр байрлах систем рүү шууд дамжуулдаг байх юм.

¹³ Байгаль орчны төлөв байдлын тайланг БОАЖЯ-наас 2 жилд нэг удаа гаргадаг бөгөөд уг тайланд орох мэдээллийг БОАЖЯ-ны холбогдох газар хэлтсүүдээс авч оруулдаг. Тайланд цаашид тулгарч байгаа зорилт болон байгаль орчны асуудлаар гарч байгаа ахиц дэвшил мөн БОАЖЯ-наас зарцуулсан төсвийн талаар тайлагнадаг.

Зураг 4: СНСМС-д санал болгож байгаа бүтэц

Монгол орны СНСМС-ийн бүтцийг санал болгосон нь – нэгдсэн систем



Шигтгээ 3: Монгол улсад байгуулах СНСМС-ийн вэб хуудас ямар онцлогтой байх талаарх зөвлөмж

СНСЗ болон СНСМС-ийн техникийн ажлын хэсэг болон бусад холбогдох талуудтай уулзаж хэд хэдэн удаагийн хэлэлцүүлэг хийсний үр дүнд СНСМС-ийн цахим хуудас болон мэдээлэл түгээх зарчмуудын талаар дараах зөвлөмжийг нэгтгэн боловсрууллаа.

- СНСЗ болон СНСМС-ийг олон нийтэд нээлттэй танилцуулж мэдээлэл өгөх цахим хуудсыг байгуулах нь зүйтэй.
- Хэрэглэгч нь СНСЗ-уудыг хэрхэн тусгаж хэрэгжүүлж байгаа талаар мэдээллийг хайх, уншихаас гадна тодорхой мэдээллийг татаж авах (мэдээ хүснэгт, зураг) боломжтой байна.
- Хэрэглэгч нь холбогдох байгууллагуудад саналаа өгч болдог байх ёстой.
- Тухайн вэб хуудас нь үндэсний болон орон нутгийн түвшний холбогдох вэб хуудсуудтай тухайлбал Үндэсний REDD+-ийн цахим хуудас, YOMC, аймгийн албан байгууллагуудын вэбсайт зэрэгтэй холбогдсон байна.
- Талуудад, ялангуяа алслагдсан газарт амьдарч байгаа иргэдэд мэдээллийг түгээхдээ мэдээллийн хуудас болон олон нийтийн мэдээллийн сүлжээг ашиглах нь зүйтэй. Монгол орны UN-REDD үндэсний хөтөлбөр олон нийтийн мэдээллийн хэд хэдэн сувгуудыг ашигладаг.
- Хяналт буюу мониторинг хийх зорилгоор СНСМС-ийн хэрэглэгчдийн статистик мэдээллийг цуглуулдаг байх шаардлагатай. Уг мэдээллийн системд хэдэн хэрэглэгч хандсан, хэр их мэдээлэл татаж авсан зэрэг мэдээг цуглуулдаг байх г.м.

СНСМС-ийг үндэсний REDD+ Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шатуудтай нийцүүлэн **2 үе** шаттайгаар хөгжүүлэхийг санал болгосон.

1-р шатны СНСМС: 2019 – 2020

Энэ эхний шатанд дараах алхмуудыг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Мэдээллийн системийн санал болгож байгаа эксел хувилбар дээр нь СНСМС-д оруулах шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж эцэслэх шаардлагатай. Үүнийг REDD+-ийн хяналт үнэлгээний тогтолцоотой холбож өгсөн байна.
- Үндсэн онлайн мэдээллийн сангуудаас (YOMC, БОМТ-ийн мэдээллийн сангууд, ГЗБГЗЗГ, ҮСХ) мэдээлэл бүрдүүлэх шаардлагатай шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, мэдээллийн системийн үнэлгээний хүснэгтэд тодорхой оруулж өгөх нь зүйтэй.
- Нэг гол мэдээллийн санг сонгож аван эхний байдлаар нэгтгээд (YOMC) БОМТ-ийн платформ дотор онлайн СНСМС-ийг байгуулах зөвшөөрөл авах хэрэгтэй.
- Эхний онлайн мэдээллийн сантай холбоход шаардлагатай аппликэйшнийг боловсруулж түүнийгээ БОМТ-ийн платформ дээр байгуулна.
- Энэ системийн аргачлалыг амжилттай туршиж үзсэний дараа (бусад мэдээллийн сангуудаас мэдээлэл авах шаардлагатай болдог) үлдсэн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлно (тухайлбал БОМТ-ийн бусад мэдээллийн сангууд, ГЗБГЗЗГ, ҮСХ гэх мэт). Мэдээллийн сангуудыг нэгтгэх ажлыг үргэлжлүүлнэ (мэдээлэл солилцоход шаардлагатай зөвшөөрөл, гэрээг бүрдүүлэх).
- Зарим мэдээллийн шалгуурыг хангахын тулд одоо байгаа маягтуудаар эсвэл шинээр маягт үүсгэн мэдээлэл цуглуулж СНСМС-д гараар шивж оруулах (ОБЕГ, МХЕГ гэх мэт) эсвэл үндэсний болон орон нутгийн түвшинд REDD+-ийн хяналт, үнэлгээг хийх явцад цуглуулж, оруулах шаардлагатай болдог тул ийм төрлийн шалгуурыг эхлээд тодорхойлно.
- СНСМС дэх үргэлжилсэн текст болон тайлбар хэсгийг бэлдэж загварыг нь тогтоож, СНСЗ-уудтай холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх бусад хэлбэр, вэбсайтыг бий болгох дараагийн алхмуудаа хэрэгжүүлэх (дараагийн 2-р үе шатанд мэдээллийн системийг хөгжүүлэхтэй холбоотой) шаардлагатай.
- СНСМС-ийг ажиллуулах удирдамж боловсруулах (2-р шатанд эцэслэнэ) зэрэг болно.

2-р шатны СНСМС: 2021 – 2024

2-р шатанд СНСМС-ийн мэдээллийн сангуудыг бусад холбогдох гол мэдээллийн эх үүсвэрүүдтэй холбох, мэдээллийг түгээх хувилбаруудыг боловсронгуй болгох ажлуудыг хийнэ (жишээ нь: вэб хуудас г.м). Үүнд:

- СНСМС-д онлайн цахим эх үүсвэрүүдээс нийлүүлж байгаа мэдээллийг нэгтгэх сайжруулах ажлыг үргэлжлүүлэх (орон зайн мэдээллийг уг системд оруулах ажлыг сайжруулах);
- Бусад эх үүсвэрээс цуглуулах мэдээллийг авахад зориулсан маягтуудыг хуулж авах эсвэл шинээр боловсруулах, (үе шат 1-д тодорхойлсон) холбогдох байгууллагуудтай мэдээлэл солилцохын тулд бүрдүүлбэл зохих гэрээ болон бусад бичиг баримтыг байгуулах;
- СНСМС-д нэмэлт мэдээлэл оруулахад ашиглах маягтуудыг туршиж үзэх, холбогдох байгууллага, агентлагуудад СНСМС-д мэдээлэл оруулах, уг системийг ашиглах талаар сургалт явуулах;

- Нэмэлт мэдээллийг системд нэгтгэх ажлыг үргэлжлүүлэх, мэдээллийн жигд, зөрүүгүй байдлыг үнэлэх, мэдээлэл дутагдалтай болон зөрүүтэй байх зэрэг асуудлыг шийдвэрлэх;
- СНСЗ-тай холбоотой мэдээллийг түгээх бусад хувилбар болон цахим хуудсыг боловсруулах;
- СНСЗ-тай төстэй бөгөөд одоогоор боловсруулж байгаа системүүдтэй холбогдох боломжийг хайж СНСМС-ийн хоёрдугаар шатны зорилгод хамаарах нэмэлт шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах (Жишээ нь ойн салбар дахь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүнийг сааруулах хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа талаар гэх мэт);
- СНСМС болон НҮБ-ын УАӨСК-д СНСЗ-уудын хэрэгжилтийн талаар өгөх тайланг боловсруулахад иргэний нийгмийн байгууллага ямар үүрэгтэй оролцохыг судалж тодорхойлох тухайлбал мэдээллийг хянах, тайланг баталгаажуулах гэх мэт;
- СНСМС-ийг ажиллуулах удирдамж, зааврыг эцэслэж шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулж 2-р шатанд хэрэгжүүлэх зэрэг болно.

4. СНСМС-ийг ажиллуулахтай холбоотой хэрэгцээ шаардлага

Энэ хэсэгт Монголд СНСМС-ийг ажиллуулахад шаардагдах зүйлсийн талаар авч үзлээ. Үүнд: холбогдох бодлого, институцийн зохион байгуулалттай холбоотой хэрэгцээ, хүний нөөц, шаардлагатай технологи тоног төхөөрөмж зэргийг багтааж ойлгоно. Дээрх шаардлагыг хангахын тулд зохих санхүүжилтийг хангах асуудлыг мөн харгалзаж үзнэ. СНСМС-ийг урт хугацаанд ажиллуулахад дараах зүйлийг бүрдүүлэх шаардлагатай хэмээн зөвлөв. Үүнд: Одоогийн байгаа системүүдийг аль болох түлхүү ашиглах, жишээлбэл, нэгдсэн системийн аргачлалыг ашиглах замаар, REDD+ үндэсний хөтөлбөрийн төсөвт шаардлагатай зардлыг тусгаж өгөх, СНСМС-ийг ажиллуулахтай холбоотой чиг үүргийг холбогдох тодорхойлсон байгууллагуудын чиг үүрэгт нэмж тусгах шаардлагатай. Жишээ нь: БОМТ нь уг мэдээллийн системийг өөр дээрээ байршуулах үүрэг хүлээх, ойн бодлого зохицуулалтын газар (ОБЗГ) нь захиргааны талаас нь хариуцах гэх мэт.

4.1 Бодлого болон институцийн зохион байгуулалттай холбоотой шаардлага

СНСМС-ийг ажиллуулахад шаардлагатай тогтсон бодлого, институцийн зохион байгуулалтыг бүрдүүлэхийн тулд хэд хэдэн алхмыг авч хэрэгжүүлэх шаардлагатай бөгөөд үүнийг доор хүснэгт 6-д үзүүлэв.

Монгол Улс нь олон нийтэд чиглэсэн мэдээллийн эх үүсвэрүүдийг байгуулж ажиллуулах талаар ихээхэн туршлага хуримтлуулсан нь СНСМС байгуулах, ажиллуулахад дөхөм болно. Жишээлбэл: БОМТ-ийн вэбсайт дээр байгаа олон тооны байгаль орчны мэдээллийн сан нь олон нийтэд нээлттэй бөгөөд мөн үндэсний статистикийн хорооны вэбсайт дээр тогтвортой хөгжлийн зорилтуудтай холбоотой мэдээллийн сан шинээр бий болгох гэж байна. Хэдийгээр БОМТ нь байгаль орчны мэдээллээр хангах чиг үүрэгтэй боловч (байгаль хамгаалах тухай хуулиар) шинэ мэдээллийн сан байгуулахад заавал тодорхой журмыг боловсруулдаг практик туршлага

Монголд байдаг. СНСМС болон СНСЗ-уудын мэдээллийн вэб хуудсыг нээхийн тулд зөвшөөрөл авах шаардлагатай болж болзошгүй.

СНСМС-д мэдээлэл нийлүүлэх байгууллагуудтай тодорхой гэрээ байгуулсны үндсэн дээр уг системд шаардлагатай мэдээллийг авах боломж бүрдэнэ. Чадавх бэхжүүлэх ажлыг мөн энд авч үзнэ. Тухайлбал: Эдгээр байгууллагад СНСМС-ийн тухай мөн уг системд мэдээллийг хэрхэн оруулах, мэдээллийг ашиглах талаар сургалт явуулж болно. Эдгээр гэрээнд чадавх бэхжүүлэхтэй холбоотой үүрэг хариуцлага болон боломжийг оруулж өгнө.

Институцийн зохион байгуулалттай холбоотой 3 дах гол асуудал нь СНСЗ-уудын хүрээг хэрэгжүүлэхэд (СНСМС болон НҮБ-ын УАӨСК-д өгдөг (SOI) тайланг боловсруулах г.м) иргэний нийгмийн үүрэг оролцоо ямар байхыг тодорхойлж, институцийн зохион байгуулалтад оруулж өгөх шаардлагатай. Иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо ямар байх талаар олон тооны зөвлөмж гарсныг доор үзүүлэв. (Хүснэгт 5).

Хүснэгт 6-д бодлого болон институцийн зохион байгуулалтын шаардлагыг хангахын тулд хэрэгжүүлэх алхмуудыг жагсаав.

Хүснэгт 6: СНСМС-ийг ажиллуулахтай холбоотой бодлого, институцийн зохион байгуулалтын шаардлагыг хангах алхмууд

Алхам/Үйл ажиллагаа	Хариуцах тал	Шаардлагатай нөөц
СНСМС-ийн мэдээллийн сангийн зааврыг боловсруулж батлах	ОБЗГ, БОМТ-ийн туслалцаатайгаар	Ажилтан ажиллуулна.
СНСМС-ийг ажиллуулахтай холбоотой байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлж боловсронгуй болгох. Үүнд: мэдээлэл солилцох гэрээ орно.	ОБЗГ, БОМТ-ийн туслалцаатайгаар	Ажилтан ажиллуулна.
Оролцож байгаа байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх	ОБЗГ, БОМТ-ийн туслалцаатайгаар	Ажилтан ажиллуулна. Мэргэжилтэн сургагч, сургалтын зардал
Вэбсайтын зөвшөөрөл баталгааг авах	ОБЗГ, БОМТ-ийн туслалцаатайгаар	Ажилтан ажиллуулна
СНСМС болон НҮБ-ын УАӨСК-д өгөх тайланг боловсруулахад иргэний нийгмийн үүрэг оролцоо ямар байхыг тодорхойлж санал нэгдэх	СНСЗ болон СНСМС-ийн ТАХ	Ажилтан ажиллуулна. СНСЗ болон СНСМС-ийн ТАХ-ийн уулзалтын зардал

4.2 Хүний нөөцийн хэрэгцээ

СНСМС-ийг ажиллуулах, засвар үйлчилгээг хариуцахад мөн СНСЗ-уудтай холбоотой мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эмхэтгэх, тайлан бэлтгэх, болон НҮБ-ын УАӨСК-д өгөх тайлан бэлтгэхэд хүний нөөц болон санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардлагатай. Эдгээр хэрэгцээ шаардлагыг доорх хүснэгт 7-д тоймлон харуулав.

СНСМ-ийн сан болон вэб хуудсыг ажиллуулах, засвар үйлчилгээг хариуцахад шинээр хүний нөөцийг бий болгох шаардлагатай (БОМТ дэхь СНСМС-ийн мэдээллийн сангийн ажилтан). Гэвч энэ хүний нөөцийн асуудлыг БОАЖЯ болон Ойн бодлого зохицуулалтын газрын бусад ажилтан хариуцаж болно. Учир нь вэб хуудсыг удирдах, СНСМС-ээс гарч байгаа мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эмхэтгэж тайланд оруулах ажлыг тогтсон тодорхой хугацаанд л хийх шаардлагатай тул хүний нөөцийн шаардлага нь харьцангуй бага юм (СНСМС-ийг жилд 1 удаа шинэчлэх, эсвэл НҮБ-ын УАӨСК-д өгдөг тайланг бэлтгэх үеэр гэх мэт). БОАЖЯ-ны одоогийн ажилтнууд нь мөн НҮБ-ын УАӨСК¹⁴-д өгдөг тайланг батлах, илгээх ажлыг хариуцаж болно.

Хүснэгт 7: СНСМС-д шаардлагатай хүний нөөц

Алхам/Үйл ажиллагаа	Хариуцах тал	Нөөц
СНСМС-ийн мэдээллийн санг ажиллуулах, үйлчилгээг хариуцах. Үүнд мэдээлэл цуглуулах, оруулах, бусад байгууллагуудын дунд зохицуулалт хийх ажлууд багтана.	БОМТ	СНСМС-ийн мэдээллийн санг удирдах нэг шинэ ажилтан
Серверийн засвар үйлчилгээ	БОМТ	БОМТ-ийн одоогийн сервер хариуцсан ажилтан
Вэб хуудас ажиллуулах, засвар үйлчилгээ	ОБЗГ	Ажилтан (REDD+-ийн хяналт, үнэлгээний эсвэл олон нийттэй харилцах асуудал хариуцсан ажилтан)
БОМТ, ОБЗГ болон бусад гол байгууллагын ажилтнуудад СНСМС-ийг ажиллуулах талаар сургалт явуулах	ОБЗГ нь БОМТ-ийн туслалцаатайгаар хийнэ.	Ажилтан, мөн шаардлагатай бол мэргэжилтэн, сургагч
Тайланд орох мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эмхэтгэх (байгаль орчны төлөв байдлын тайлан) НҮБ-ын УАӨСК-д өгдөг (SOI) тайлан	ОБЗГ	Дотоодын нэг ажилтан ажиллуулна (REDD+-ийн хяналт, үнэлгээний эсвэл олон нийттэй харилцах асуудал хариуцсан ажилтан) Тайлан бичих зөвлөх, багийг томилох хувилбар байж болно
НҮБ-ын УАӨСК-д өгдөг тайланг (SOI) баталгаажуулах, хянах, батлах	БОАЖЯ-ны ОБЗГ, Уур амьсгалын өөрчлөлт Олон улсын хамтын ажиллагааны газар	БОАЖЯ-ны ажилтан нь НҮБ-ын УАӨСК-д өгөх тайланг батлах ажлыг хариуцна. Зөвлөх уулзалт иргэний нийгмийн байгууллагуудыг

¹⁴ REDD+-ийг хэрэгжүүлсний үр дүнд суурилсан урамшуулал авах орнууд эхлээд НҮБ-ын УАӨСК-ийн газарт СНСЗ-үүдийн хэрэгжилтийн талаар тайлан (SOI) өгсөн байх ёстой гэсэн шаардлага байдаг. Үүний дараа уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний тайланг өгөх ёстой. Хамгийн багадаа 4 жилд нэг удаа өгнө. СНСЗ-ийн хэрэгжилтийн тайланг сайн дурын үндсэн дээр мөн хэзээ ч өгч болдог.

		тайланг батлах ажилтай холбоотой зардал гарна.
СНСЗ-ын хэрэгжилтийн талаарх тайланг НҮБ-ын УАӨСК-д өгөх	УАӨТХН, УАӨГХАГ	Ажилтан

4.3 Техникийн тусгай мэргэжилтэн, технологи тоног төхөөрөмжтэй холбоотой хэрэгцээ шаардлага

СНСМС-ийг ажиллуулахтай холбоотой мэргэжлийн болон технологийн хэд хэдэн шаардлага тавигдана. Эдгээрийн доорх хүснэгт 8-д харуулав.

Мэргэжлийн боловсон хүчний тухайд нэмэлт ИТ мэдээллийн технологийн мэргэжилтэн ажиллуулж нэгдсэн онлайн СНСМС санг байгуулах шаардлагатай бөгөөд тэр мэргэжилтэн нь БОМТ-ийн ажилтантай хамтран ажиллаж чадавхыг нь бэхжүүлнэ. Технологийн хэрэгцээ талаас 8 СНСМС-ийг ажиллуулахад тодорхой хадгалах зай талбай шаардахгүй байх хэдий ч БОМТ-д YOMC болон СНСМС-ийг хамт байршуулах учраас тус төвийн серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудлыг харгалзах шаардлагатай болно. Серверийн үзүүлэлтүүд: LINUX үйлдлийн системтэй, 4GB RAM, 64GB SSD хардтай байна. БОМТ-ийн PostgreSQL¹⁵ сервер дээр байршуулна. Үүнээс гадна БОМТ-д СНСМС-ийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд тодорхой мэдээллийн технологийн тоног төхөөрөмж хэрэгтэй болно.

Хүснэгт 8: Хүний нөөц, технологи, тоног төхөөрөмжийн шаардлага

Алхам/Үйл ажиллагаа	Хариуцах тал	Шаардлагатай нөөц
ИТ-ийн мэргэжилтнээс зөвлөгөө авч СНСМС-ийг бусад онлайн мэдээллийн сангуудтай холбох ажилд хяналт тавих, аппликейшн хөгжүүлэх	БОМТ	Үндэсний ИТ мэргэжилтэн
СНСМС болон YOMC-ийг байршуулахтай холбоотойгоор БОМТ-ийн сервер болон серверийн өрөөг өргөтгөх, серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх санхүүжилт олгох	БОМТ	Серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зардал
БОМТ-д нэмэлт мэдээллийн технологийн тоног төхөөрөмж (компьютер, принтер) олгох	БОМТ	Нэмэлт мэдээллийн тоног төхөөрөмжийн зардал(компьютер, принтер)

¹⁵ PostgreSQL гэдэг нь ерөнхий зориулалтын мэдээллийн сангийн менежментийн систем бөгөөд үнэгүй, нээлттэй программ юм.

5. Зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх алхмууд

Энэхүү баримт бичигт Монгол Улсад байгуулахаар зорьж байгаа СНСМС-ийн загварыг санал болгосон бөгөөд уг баримт бичгийг боловсруулахдаа тус улсад хэрэгжүүлэх СНСЗ-уудын хүрээ, талуудтай хийсэн зөвшилцөл, одоогийн байгаа мэдээллийн системүүдийг эрэмбэлсэн ажлын үр дүн зэрэгт суурилсан болно. Үүнд санал болгож байгаа мэдээллийн бүтцийн талаар нарийвчилсан мэдээлэл, системийн үйлдэл, холбогдох байгууллага талуудын гүйцэтгэх үүрэг, мэдээллийн системийн санал болгож байгаа бүтэц зэргийг багтаасан. Мөн энд системийг байгуулахтай холбоотой авч хэрэгжүүлэх алхам болон шаардлагатай нөөцүүдийн талаарх мэдээллийг орууллаа.

СНСМС-ийг цаашид ажиллуулахтай холбоотой хэд хэдэн зөвлөмжийг боловсруулсныг хураангуйлав. Үүнд:

- Нэн тэргүүнд хэрэгжүүлэх алхам бол эхний шатны СНСМС-ийн мэдээллийн санг байгуулах ажиллуулахтай холбоотой төсвийг REDD+-ийн Үндэсний хөтөлбөрийн баримт бичигт тусгах шаардлагатай, учир нь СНСМС нь REDD+-ийн гол бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг юм. REDD+-бүрэлдэхүүн удирдах байгууллагад СНСЗ ба СНСМС-ийг удирдах зохион байгуулах чиг үүрэг, санхүүжилтийг зохих ёсоор бүрдүүлж өгөх шаардлагатай юм.
- СНСМС-д оруулах шалгуур үзүүлэлтүүдийг санал болгосон. Хэдий тийм боловч эдгээр шалгуур үзүүлэлтүүдийг цаашид хэлэлцэж, батлах, тэдгээрийг REDD+-ийн хяналт болон үнэлгээний ерөнхий зарчимд нийцүүлэн холбогдох зорилт, шалгуур үзүүлэлтүүдтэй нь нэгтгэх, уялдуулах талаар ажиллах шаардлагатай. Агуулгыг бэлдэх, онлайн СНСМС-ийн мэдээллийн санг эхний байдлаар байгуулах зэрэг үйл ажиллагааны явцад дээрх шалгуур үзүүлэлтүүдийг уялдуулж цаашид сайжруулж байх нь зүйтэй.
- Монгол Улсын ЗГ-аас (БОАЖЯ) БОМТ-д СНСМС-ийг байгуулж ажиллуулах талаар шийдвэр гаргах нь зүйтэй. Энэ мэдээллийн санг байгуулж, ажиллуулах талаар БОМТ-ийн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгасан байх шаардлагатай.
- REDD+-ийг Монгол Улсад хэрэгжүүлэх арга зам, үйл явц улам боловсронгуй болохын хэрээр REDD+-ийн бодлого, арга хэмжээнүүдийг үндэсний болон орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж эхлэх бөгөөд үүнд шаардагдах тодорхой нөөц эх үүсвэрүүд бүрдэнэ. Тэр үед СНСМС-ийн зорилго, загварыг бас дахин шинэчлэх шаардлагатай болж болзошгүй. Ингэснээр уг мэдээллийн систем нь REDD+-ийн хэрэгжилт болон хяналтын үйл ажиллагаатай уялдах юм.
- Эцэст нь тэмдэглэхэд, СНСЗ-уудын хэрэгжилтийн талаар НҮБ-ын УАӨСК-д өгөх тайлангийн (SOI) талаар энэ баримт бичигт товчхон авч үзсэн бөгөөд уг тайланд орох мэдээллүүд нь СНСМС-ээс гарах боломжтой юм. Монгол Улс нь REDD+-ийн үр дүнд суурилсан урамшуулал авахын тулд /SOI/ буюу СНСЗ-уудын хэрэгжилтийн тайланг бэлтгэх ёстой бөгөө уг тайланг боловсруулах нарийвчилсан ажлын төлөвлөгөөг гаргах шаардлагатай. Уг төлөвлөгөөнд СНСМС-ийн мэдээллийг хэрхэн ашиглах, НҮБ-ын УАӨСК-д өгөх тайланг хэрхэн хянах, баталгаажуулах, иргэний нийгмийн оролцоотой байх эсэх, тайланг батлах, конвенцэд илгээх журмуудын талаар оруулсан байна.



Ойн хомсдлоос
үүдэлтэй хүлэмжийн
хийн ялгарлыг
бууруулах

Reducing emissions
from deforestation

Ойн доройтлоос
үүдэлтэй хүлэмжийн
хийн ялгарлыг
бууруулах

Reducing emissions
from forest degradation

Ойн
нүүрстөрөгчийн
хуримтлалыг
хамгаалах

Conservation of
forest carbon stocks

Ойн тогтвортой
менежмент

Sustainable
management of forest

Ойн нүүрстөрөгчийн
хуримтлалыг
нэмэгдүүлэх

Enhancement of
forest carbon stocks

REDD

+



UN-REDD PROGRAMME



Food and Agriculture
Organization of the
United Nations



Empowering lives.
Resilient nations.



Монгол орны UN-REDD Үндэсний Хөтөлбөр

Хаяг: Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж
5/2, Чингэлтэй дүүрэг, Улаанбоотор 15160,
Монгол улс

Утас: +976-7711-7750

Цохим шуудан: info@unredd.mn

Вэбсайт: www.reddplus.mn